

XANADU MINES

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

2022

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон



ASX:XAM | TSX:XAM

XANADUMINES.COM

Урьдчилсан МЭДЭГДЭЛ

Энэхүү баримт бичигт тус Компани өөрийн туршлага, ойлголт дээр тулгуурлан гаргаж ирсэн тодорхой таамаглал, дүн шинжилгээнүүд дээр үндэслэсэн урьдчилсан мэдэгдлүүд орсон болно. Энд дурдагдсан эдгээр урьдчилсан мэдэгдлүүд нь тухайн үед урьдчилан таамаглахад хүндрэлтэй ашигт малтмалын нөөц, баялагтай холбоотой зорилт, тооцоолол, таамаглал зэрэг мэдэгдлүүд, металлын таамаг зэрэг, металл авалт, үйлдвэрлэл, үнэ, металл авалтын зардал ба үр дүн, капитал зардал зэрэг тус Компанийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй томоохон эрсдэл, тодорхойгүй байдал зэргээс хамаарах ба ирээдүйн техник, нийгэм, эдийн засаг, зах зээл, улс төрийн болон бусад нөхцөл байдлуудаас мөн хамаарна. Эдгээр урьдчилсан мэдэгдлүүдийг гаргах үндэслэл болсон таамаглал, судалгаа шинжилгээний үр дүнг Занаду компани ашиглах боломжтой гэж үзсэн хэдий ч эдгээр нь техник, бизнес эдийн засаг, өрсөлдөөн, улс төрийн болон нийгмийн тодорхойгүй, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлаас хамаарах бөгөөд улмаар уг урьдчилсан мэдэгдлүүдэд тусгагдсан үйл явдал, төсөөллийн үр дүнгээс ноцтой хэмжээнд зөрөх үйл явдал, үр дүнд хүргэж болзошгүй мэдэгдэх болон үл мэдэгдэх эрсдэл, тодорхойгүй байдлууд байна. Итгэх, хүлээх, таамаглах, заах, тунгаах, зорих, төлөвлөх, чиглэх, үргэлжлүүлэх, төсөвлөх, тооцоолох, ...-ж болох, ... хийх, хуваарь гаргах болон бусад ижил төстэй үгсийг ашиглах нь урьдчилсан мэдэгдэл болохыг харуулна. Энэхүү тайланд тусгагдсан урьдчилсан мэдэгдлүүд нь тус тайланг боловсруулах үеийн байдлаар хийгдсэн бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд тус Компани нь ирээдүйд болох үйл явдал, шинээр гарч ирэх мэдээллийн дүнд үүсэх нөхцөл байдалтай холбоотой аливаа урьдчилсан мэдэгдлийг шинэчлэх эсвэл засварлах үүрэг, зорилго хүлээхгүй болно.



Агуулга

04

ТУЗ-ийн Даргын
мэндчилгээ

08

Занаду-гийн
тухай

10

Компанийн
тухай

12

Зижинь Уул уурхайн
групптэй тогтоосон
стратегийн түншлэл

15

Бидний
үнэт зүйлс

16

Бидний тогтвортой
байдлын баримтлах
зарчим

17

Материаллаг
байдлын үнэлгээ

21

Засаглал

24

Үнэ цэнийг
бүтээж, бүх
оролцогч
талуудын идэвх
оролцоог хангах

30

Манай хамт
олон

36

Бид нутгийн
иргэдийг анхаарч
халамжилдаг

44

Байгаль орчинд
үзүүлэх одоогийн
болон ирээдүйн
нөлөөллийг
бууруулах

50

Тогтвортой
байдлын
тогтолцоо

61

Байгууллагын
удирдлага

ТУЗ-ийн дарга болон Удирдах захиралын мэндчилгээ



Колин Мурхэд

ТУЗ-ийн дарга болон Удирдах захирал

Занаду Майнз ХХК (“Занаду Майнз”, “Занаду” эсвэл “Компани” гэх) компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Тогтвортой Байдлын Тайланг танилцуулж байгаадаа баяртай байна. Энэхүү тайлан нь манай гурав дахь удаагийн Тогтвортой Байдлын Тайлан бөгөөд Глобал Тайлагналын Санаачлага (ГТС/GRI) стандартын дагуу, Олон Улсын Уул Уурхай, Металлын Зөвлөл (ОУУУМЗ)-ийн олборлолтын зарчмууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (НҮБ ТХЗ)-ын дагуу тайлагнасан болно.

Занаду компани Монгол Улсад порфирын төрлийн зэс-алтны орд нээн илрүүлэх үйл ажиллагаа явуулдаг хайгуулын компани юм. Уул уурхайн салбарт ажилладаг компанийн хувьд бид өөрсдийн бизнесийн үйл ажиллагааг тогтвортой хэлбэрээр, Монгол Улсын байгаль орчин, олон нийтэд сөрөг нөлөөлөл учруулахгүй байдлаар явуулах нь асар чухал ач холбогдолтой гэдгийг ойлгож байна. Тогтвортой байдал бол бидний ажилдаа мөрдөх гол үнэ цэнүүдийн нэг юм.

Бид тогтвортой хайгуул, хөгжлийн чиглэлээр тэргүүлэгч байхыг эрмэлздэг бөгөөд энэ нь манай Тогтвортой Байдлын Бодлогод тусгагдсан олон зорилтуудад тусгалаа олсон байдаг. Эдгээр зорилтуудад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, манай компанийн үйл ажиллагаа явуулдаг улс болох Монгол Улсын Засгийн Газар болон олон нийттэй бат бэх харилцаа тогтоох, ил тод, ёс зүйтэй ажиллах зэрэг зорилтууд багтана. Манай Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Хөдөлмөрийн Аюулгүй Байдал, Эрүүл Ахуй болон Байгаль Орчны Хороогоор дамжуулан компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хянаж ажилладаг.

Энэ жил бид бодит байдлын үнэлгээ хийх замаар өөрсдийн Тогтвортой Байдлын Тайлагналд нэмэлт ахиц гаргалаа. Энэхүү бодит байдлын үнэлгээний зорилго нь манай болон бидний оролцогч талуудад тулгарч буй тогтвортой байдлын хамгийн ноцтой асуудлуудыг олж тогтоох, эрэмбэлэхэд туслах явдал юм. Бид Занаду компанийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлж, тасалдал гаргаж болзошгүй, эсвэл оролцогч талуудын хувьд ноцтой гэж тооцогдохуйц асуудлуудыг манай ноцтой асуудлууд гэж тодорхойлдог.

Тайлант жилийн хувьд манай компанийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн үзүүлэлтүүдээс дурдахад, ажиллах хүчний дунд гэмтэл, амь нас алдахад хүргэсэн осол зөрчилгүй ажилласнаа тайлагнахад таатай байна. Энэ бол бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж, олон нийттэй үр дүнтэй хамтран ажиллах чиглэлээр идэвхтэй ажиллаж байгаагийн илрэл юм. Энэ жилийн Тогтвортой Байдлын Тайлангаас бид олон нийтэд хандаж боловсролын чиглэлээр туслалцаа үзүүлэх, орон нутгийн боловсролын дэд бүтцийг барьж байгуулах, компанийн эрчим хүч болон усны хэрэглээ, нүүрстөрөгч ялгаруулалтын талаар Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын мэдээ өгөгдөл боловсруулах зэрэг нэмэлт ажлуудыг хийсэн болохыг харж болно. Бид өөрсдийн үйл ажиллагааг хариуцлагатай явуулж, байгаль орчны болон нийгмийн чиглэлээр хийж гүйцэтгэх ажлын гүйцэтгэлийг сайжруулах эрмэлзэл дүүрэн байна.

Биднийг үргэлж дэмжиж байдаг та бүхэнд баярлалаа. Бид хамтдаа ирээдүйд ихийг хийж бүтээж чадна гэдэгтээ итгэлтэй байна.



Бид өөрсдийн үйл ажиллагааг
хариуцлагатай явуулж, байгаль
орчны болон нийгмийн
чиглэлээр хийж гүйцэтгэх
ажлын гүйцэтгэлийг сайжруулах
эрмэлзэл дүүрэн байна.”

Колин Мурхед | ТУЗ-ийн Дарга, Удирдах Захирал



Үйл ажиллагаа хариуцсан захиралын МЭНДЧИЛГЭЭ



Мөнхсайхан Дамбийням

Үйл ажиллагаа хариуцсан захирал

Энэ жилийн хувьд Занаду компанийн онцлох мэдээлэл нь Занаду Майнз компани болон Зижинь Майнинг Групп ХХК (“Зижинь” гэх)-ийн хооронд стратегийн түншлэл байгуулагдсаныг зарласан явдал бөгөөд энэ нь манай тогтвортой байдлын хөгжилд үлэмж хувь нэмэр оруулах болно. Энэ түншлэлийн тусламжтайгаар Зижинь компани Занаду-д 11 сая хүртэлх австрали долларын хөрөнгө оруулалтыг үе шаттай оруулах ба Хармагтай төсөлд нэмэлтээр 35 сая хүртэлх америк долларын хөрөнгө оруулах юм. Зижинь компанийн хөрөнгө оруулалт 2023 оны эхээр орсноор Хармагтай төслийн хэрэгжилт бодит болох нөхцөл бүрдлээ.

2022 онд бид Монгол Улс дахь түншүүдийнхээ сайн, хариуцлагатай нөхөд, хөршүүд нь байх замаар өөрсдийн тогтвортой байдлын үнэ цэнийг үргэлжлүүлэн авч явж байснаа тайлагнахад таатай байна. Бид өөрсдийн баг хамт олны аюулгүй ажиллагааг хангаж, байгаль орчинг хайрлан хамгаалж, бидний үйл ажиллагаа явуулж буй нутгийн ард олонд дэмжлэг үзүүлэх замаар хайгуулын үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацааны онцлох үйл явдлуудаас дурдвал:

- Ажилтнуудад 350 гаруй цагийн дадлагажуулалт, сургалт хийв.

- Нийт ажилласан хүн цаг 52,000 гаруй болсноос гэмтлийн улмаас алдагдсан цаг 0, нас барсан хүний тоо 0
- Нутгийн ард иргэдтэй үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна
- Ард иргэдийн гомдол саналыг амжилттай барагдуулсан
- Орон нутгийн боловсролын дэд бүтцийг байгуулж, нутгийн иргэдэд боловсролын тусламж үйлчилгээ үзүүлэх замаар тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж байна.
- 2022 онд бид Хармагтай болон Улаан Уул төслүүдээс 43 оюутанд их дээд сургуульд суралцахад нь тусламж үзүүлсэн нь 2021 оны тоотой харьцуулахад эрс нэмэгдсэн билээ.

Цаашид Зижинь-тэй тогтоосон манай стратегийн түншлэл Занаду компанийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийг улам бэхжүүлж бүх оролцогч талуудад урт удаан хугацаанд мэдрэгдэх үнэ цэнийг бүтээх боломж олгоно гэдэгт итгэлтэй байна.

2022 онд бид Монгол Улс дахь
түншүүдийнхээ сайн, хариуцлагатай
нөхөд, хөршүүд нь байх замаар
өөрсдийн тогтвортой байдлын
үнэ цэнийг үргэлжлүүлэн авч явж
байснаа тайлагнахад таатай байна.”

Мөнхсайхан Дамбийням | Үйл ажиллагаа хариуцсан захирал



Занаду Майнз компаний тухай

Занаду Майнз нь дэлхийн хэмжээнд порфирын төрлийн зэс – алтны ордыг олж илрүүлэх, тогтоох чиглэлээр мэргэшсэн боловч Монгол Улсад голлон үйл ажиллагаа явуулдаг хайгуулын компани болно. Бид Монгол Улсад 10 гаруй жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай бөгөөд бидний найдвартай, хүчирхэг харилцаа холбоо бидэнд зардал багатай, үр дүнтэй байдлаар баялгийг нээн илрүүлэх, нөөцийг нэмэгдүүлэх боломж олгодог. Бидний хайгуулын төслүүдийн хэрэгжилтийн үе шатууд нь олон янз. Манай тэргүүлэх төсөл болох Хармагтай төсөл нь 1-р зэрэглэлийн зэс-алтны орд бөгөөд бид уг ордыг хяналтдаа байлгадаг цөөн тооны жижиг хайгуулын компаниудын нэг хэвээр байна. Бид Монгол Улс дахь зэс-алтны томоохон орд илрэлүүдээр дамжуулан, уурхайн олборлолтын мөчлөгийн оргил үед нь хувь эзэмших боломж олгох замаар хувьцаа эзэмшигчдэдээ үнэ цэнийг бүтээдэг. Энэ бүх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бид төслүүдийг анх олж илрүүлэхээс эхлээд урьдчилсан ТЭЗҮ боловсруулахын өмнөх шат хүртэлх хугацаанд бага зардлаар нээж, хөгжүүлдэг болно.



Компаний тухай

Бид бол дэлхийн хэмжээнд үнэлэгдэх порфирын төрлийн зэс-алтны ордуудыг нээн илрүүлж, хөгжүүлдэг хайгуул, хөгжлийн компани билээ. Бид энэ улсад арав гаруй жил ажилласан туршлагатай ба энэхүү туршлага дээрээ үндэслэн бид ашигт малтмалын орд, нөөцийг бага зардлаар, үр дүнтэй нээн илрүүлж, хөгжүүлдэг. Манай хэрэгжүүлж буй төслүүдийн хэрэгжилтийн явц янз бүр бөгөөд манай гол нэрийн хуудас болсон төсөл нь Хармагтай зэс-алтны төсөл юм.

1

Төсөл боловсруулалт

Монгол Улсын Өмнөговь аймагт цаашид орд болох ирээдүйтэй талбайг нээн илрүүлэхийг зорьж байна.



Шинэ төслийн идэвхтэй хайлт

2

Зорилт үүсгэх

Геологи, геохими, геофизикийн мэдээлэл олж авах



Улаан уул (100%)

Өрөмдлөг хийх цэгүүдийг тогтоох зорилгоор суваг татаж байна

3

Зорилт турших

Өрөмдлөг хийх замаар шинэ нээлтүүдийг чиглэх

4

Төслийн тодорхойлолт

Нөөц тогтоох судалгаа

Дэлхийд чухалд тооцогдох Ашигт Малтмалын Нөөцийн Тооцоолол 1



Хармагтай (38.25%)²

Урьдчилсан ТЭЗҮ-с үзэхэд тус төсөл нь эдийн засгийн өндөр үр ашигтай нь тогтоогдсон

Зижинь компанитай стратегийн түншлэл тогтоосноос хойш урьдчилсан ТЭЗҮ болон хайгуулын зардлыг бүрэн санхүүжүүлсэн.

5

Үнэ цэнийг бий болгох

Төслийг хэрэгжүүлэх зорилгоор худалдан борлуулах, эсвэл хамтарсан компани байгуулах

¹ Австралийн Хөрөнгийн Бирж/Торонтогийн Хөрөнгийн Бирж (ASX/TSX)-ийн мэдэгдэл 2021 он 12 сар 08 өдөр - Хармагтай ордын нөөц 1.1 тэрбум тонн болж нэмэгдэв. Үүнд 3 сая тонн зэс, 8 сая унц алт

² Австралийн Хөрөнгийн Бирж/Торонтогийн Хөрөнгийн Бирж (ASX/TSX)-ийн мэдэгдэл 2023 он 03 сарын 13 өдөр - Зижинь болон Занаду компанийн арилжаа эцэслэгдэж, Хармагтай төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулах ажил эхлэв.

Бид дараах замаар хувьцаа эзэмшигч нартаа үнэ цэнийг бүтээнэ. Үүнд:

- Монгол Улсад томоохон хэмжээний зэс-алтны орд илэрцийг эзэмших
- Уурхайн олборлолтын мөчлөгийн оргил үед хувьцаа санал болгох
- Орд илэрцийг нээн илрүүлэхээс эхлээд урьдчилсан ТЭЗҮ боловсруулах шат хүртэл хугацаанд бага зардлаар нээлт, хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэх



Монгол Улс дахь манай стратегийн давуу талууд:

- Ордын хэмжээ – Дэлхийд томд тооцогдох орд илрэлүүд, цаашид мөн нэмэлт хайгуул судалгаа хийх шаардлагатай
- Байршил – Дэлхийн зэсийн гол хэрэглэгч болох Хятад улстай ойр, хүн ам сийрэг суурьшсан өргөн том талбай
- Дэд бүтэц – Цахилгаан эрчим хүч, авто болон төмөр зам харилцаа, усны дэд бүтэц бүхий Рио Тинто компанийн Оюу Толгой төсөлтэй ойрхон байршиж буй тул үйлдвэрлэл явуулж эхлэх хугацаа богино, капитал зардал бага шаардагдана.
- Уул уурхайн соёл – Уул уурхайн салбар тус улсын ДНБ-ий 21%, экспортын 85%-ийг бүрдүүлж буй бөгөөд 40,000 гаруй Монгол мэргэжилтнүүд, ажилтнууд уул уурхайн салбарт ажиллаж байна.
- Тогтвортой, ардчилсан улс – Ардчилсан сонгууль явуулж ирсэн 30 жилийн туршлага, хүн амын 98% нь бичиг үсэгт тайлагдсан.

Зижинь Уул Уурхайн Групп-тэй тогтоосон стратегийн түншлэл

2022 онд Занаду компани өөрийн гол төсөл болох Хармагтай зэс-алтны төсөл (Хармагтай)-ийн үнэлгээг хийх, цаашдын хөгжлийн талаар шийдвэр гаргах үүднээс Жижинь Уул Уурхайн Групп ХХК (Жижинь)-тай стратегийн түншлэл байгуулсан бөгөөд уг ажлыг 2023 оны эхээр хийж гүйцэтгэсэн болно¹. Энэхүү Гэрээний дагуу Жижинь компани Занаду компани нь Хармагтай төсөлд хөрөнгө оруулсан ба Занаду Компанид 19.4% эзэмшиж, Хармагтай төслийн 76.5 хувийг эзэмшдэг Хүйтэн Металлс Пте Лимитед компанид 50/50 хувийн хамтарсан компани байгуулсан юм.

Зижинь Уул Уурхайн Группын тухай

Зижинь бол дэлхийн хэмжээнд алт, зэс, цайр болон бусад ашигт малтмалын хайгуул эрхлэх, орд нээн илрүүлэх, хөгжүүлэх, ашигт малтмал баяжуулах, боловсруулах, арилжих болон бусад бизнес эрхлэх зорилго бүхий үндэстэн дамнасан уул уурхайн групп юм. Тус компани Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын 14 муж болон Европ, Төв Ази, Африк, Далайн Орнууд болон Өмнөд Америкийн 13 улсад төслийн болон олборлолтын үйл ажиллагаа явуулдаг, дотоодын болон олон улсын зэс, алтны ордын нөөц, баялаг, олборлолтын хэмжээгээр Хятад улсын хамгийн томд тооцогдох уул уурхайн компаниудын нэг юм.


**Зижинь компанийн БНХАУ дахь уул уурхай,
олборлолтын үйл ажиллагаа**



**Зижинь компанийн гадаад улс орнууд дахь уул
уурхай, олборлолтын үйл ажиллагаа**



1 ASX/TSX Announcement 13 March 2023 – Zijin and Xanadu Transaction Completed and Kharmagtai PFS Underway



Манай төслүүд болон тэдгээрийн төлөв

Хармагтай Дүүрэг (Занаду 38.25%, Зижинь 38.25%)

Манай нэрийн хуудас болсон Хармагтай Дүүрэг нь дэлхийд тэргүүлэх хэмжээний зэс, алтны ашиглагдаагүй орд гэж тооцогдсон хэвээр байна. Хармагтай бол маш ирээдүйтэй зэс-алтны порфирын дүүрэг бөгөөд Өмнөговь аймагт, Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 420км орчим, Рио Тинто компанийн Оюу Толгой төслөөс хойд зүгт 120км зайд оршино. Хармагтай ордын ЖОРК (JORC) стандартын нөөц одоогийн байдлаар 1.1 тэрбум тонн, үүнд: зэс 3 сая тонн, алт 8 сая унц гэж тогтоогдсон бөгөөд энэхүү нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх хайгуул, судалгааны ажлыг эрчимтэй хийж байна.

Сүүлийн тайлан гарснаас хойш Занаду Майнз Лтд ("Занаду" эсвэл "Компани" гэх) нь тус Компанийн гол төсөл болох Хармагтай Зэс-Алтны Төсөл ("Хармагтай" гэх)-ийг цаашид хөгжүүлэх чиглэлээр голлон анхаарсан болно. Энэ хүрээнд Нөөцийн Судалгаа, Үндэсний 43-101 Техник Эдийн Засгийн Урьдчилсан Үнэлгээ

(ТЭЗҮ) хийлгэж, Зижинь Уул Уурхайн Групп компанитай стратегийн түншлэл тогтоож Хармагтай төслийг урьдчилсан ТЭЗҮ-гээс бүтээн байгуулалтын шат руу шилжүүлэх санхүүгийн болон техникийн экспертиз үйлчилгээ авахаар болсон байна.

2023 онд хийгдэх ажлууд:

- Хармагтай төслийн урьдчилсан ТЭЗҮ-ийн ажил 2023 оны 03 сард хийгдэж эхэлсэн. Олборлолт хийх шийдвэр 2024 онд гарна.
- Хармагтай ордын өндөр агуулгатай бүсийг тэлэх, шинэ нээлт хийх хайгуул.
- Сүүлийн үеийн гүехэн, өндөр агуулгатай борнитын судлын дагуу Улаан Уул талбайд хайгуул хийх.



Хармагтай төслийн анги

Улаан Уул Дүүрэг (Занаду 100%)

Улаан Уул зэс-алтны дүүрэг нь Монгол Улсын өмнөд хэсэг Дорноговь аймагт, Сайншанд аж үйлдвэрийн төвлөрсөн бүсээс 70км орчим зайд оршино. Улаан Уул нь маш ирээдүйтэй, бүрэн судлагдаагүй, хайгуул бага хийгдсэн порфирын

төрлийн зэс, алтны дүүрэг бөгөөд 40км квадрат орчим талбайтай. Геологийн нөхцөл нь олон төрлийн порфирын төрлийн зэс-алтны төвүүд, эрдэсжсэн турмалин брекч хоолой, зэс-алт/суурь металл магнетит скарнуудаас бүрдэнэ.

ҮНЭТ зүйлс

Занаду Майнз Лтд (“Занаду” эсвэл “Компани” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл энэхүү Үнэ Цэнийн Мэдэгдлийг гаргасан бөгөөд үүнд Занаду компанийн бий болгохыг зорьж буй байгууллагын төрлийг тодорхойлох, түүнд хүрэх үүднээс ТУЗ-ийн зүгээс захирлууд, гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудаас шаардах зарчим, хэм хэмжээг тодорхойлсон болно.

Занаду компанийн Үнэ Цэн нь тус Компанийн зорилго болон түүний стратегийн зорилгуудыг хооронд нь холбож компанийн зорилгыг хэрэгжүүлэхэд захирлууд, гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудад ТУЗ-ийн зүгээс тавигдах стандарт, зан төлөвийн шаардлагыг илэрхийлэх юм.

Бидний ажлыг чиглүүлдэг таван үнэт зүйлс:



Тогтвортой байдал

Бид Монгол улсад бүх талын хамтын түншлэлд хариуцлагатай, сайн хамтрагчид юм. Бид баг хамт олноо аюулгүй байлгах, хүрээлэн буй орчныг хамгаалах, үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн ард иргэдийг дэмжих замаар ажилладаг.



Үнэнч шударга байдал

Бидний хувьд компанийн нэр хүнд хамгаас эрхэм юм



Шинжлэх ухаанч байдал

Бид бүх үйл ажиллагаагаа шинжлэх ухаанд суурилан явуулдаг



Зарчимч хөрөнгийн удирдлага

Бид богино хугацааны ашиг орлогоос илүү урт хугацааны үнэ цэнийг чухалчлан өөриймсгөөр ажилладаг



Компанийн соёл, ажлын гүйцэтгэл

Бид техникийн дэвшил, инновацийг эрхэмлэдэг бөгөөд бүх түвшний ажлын байранд шилдэг хүмүүсийг татаж, авч үлдэхийг зорьдог.

Бид бие биендээ үнэнч байж, хариуцлагатай хандах, өдөр бүр үнэт зүйлсээ тууштай хэрэгжүүлэхэд үлгэр дууриалал үзүүлж, бие биеэ дэмжиж ажилладаг.

Манай тогтвортой байдлын хандлага

Энэхүү Тогтвортой Байдлын гурав дахь Тайланг гаргаснаар бид өөрсдийн Байгаль Орчин, Нийгэм болон Засаглалын өгөгдөл, практик туршлагыг өмнөх тайлангуудаас илүү нэмж баяжуулсаар ирлээ. Тогтвортой байдлын зарчмуудыг уурхайн мөчлөгийн бүх үе шатанд тодоор тусгаж, хайгуулын компанийн хувьд энэ чиглэлээр манлайлан ажиллах боломжийг эрэлхийлэх хэрэгтэй гэдэгт бид итгэдэг. Бидний үйл ажиллагаа Монгол Улсын байгаль орчин болон нутгийн ард иргэдэд нөлөөлөх боломжтой гэдгийг ойлгосон нь тогтвортой байдалд хандах бидний хандлагыг илэрхийлнэ. Бид эдгээр үр нөлөөг хариуцлагатай байдлаар удирдаж, байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлээ тасралтгүй сайжруулахыг эрмэлзэж ажилладаг. Занаду компани өөрсдийн үйл ажиллагааг

хэрэгжүүлэхдээ нутгийн ард иргэдийн эрх, ашиг сонирхлыг харгалзан, хүндэтгэлтэй хандах үүднээс нутгийн ард иргэдтэй нягт хамтран ажилладаг болно. Нутгийн оролцогч талуудад ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны талаар зөвлөгөө өгч, орон нутгийн иргэдийн дунд орж ажилласнаар хамтын үнэ цэнийг бий болгох хүчин чармайлт гаргаж байна. Бидний хувьд үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж буй үр нөлөөг анхаарч судлах нь улам бүр чухал болно. Иймд нөөцийг үр ашигтай ашиглаж, байгаль орчны удирдлагын хамгийн шилдэг арга, туршлагуудыг нэвтрүүлэх замаар байгаль орчинд үзүүлэх нөлөөг аль болох бууруулахыг эрмэлздэг. Бид байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах арга замыг тасралтгүй эрэлхийлж, тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэхийг зорьж байна.



Бодит байдлын ҮНЭЛГЭЭ

Авсралийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компанийн хувьд бид АХБ (ASX)-ийн Компанийн Засаглалын Зарчмууд болон Зөвлөмжүүдийг мөрдөж, Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ийн мэдээллүүдийг ирэх жилүүдэд тайлагнах чиглэлээр салбарын тэргүүлэх норм, дүрэм, үйл явц (Глобал Тайлагналын Санаачлага (GRI) стандарт, Олон Улсын Уул Уурхай, Металлын Зөвлөл (ОУУУМЗ)-ийн Тогтвортой Хөгжлийн Норм гэх мэт)-с чиглэл авч ажилладаг. Бид өөрсдийн ГТС, ОУУУМЗ, НҮБТХЗ-ийн индексийг энэхүү

тайлангийн сүүлийн бүлэгт тусгасан болно.

Энэ хандлагын хүрээнд бид энэ тайлангийн хамрах хүрээг тодорхойлох зорилгоор өөрсдийн бодит байдлын үнэлгээг хийсэн. Бид Занаду компанийн болон манай гол оролцогч талуудын хувьд хамгийн чухал бодит тогтвортой байдлын чиглэлүүдийг тодорхойлох, эрэмбэлэх үүднээс Accountability-ийн Таван Бүлэгт Бодит Байдлын Үнэлгээг нэвтрүүлсэн. Манай гол оролцогч талуудын талаарх нэмэлт мэдээллийг дараах дэд бүлэгт дурдав.



Хариуцлагын таван хэсэг бүхий материаллаг байдлын тест

Судалгаа:

Материаллаг байдлыг боловсруулахын тулд хэд хэдэн зүйлсийг судалсан. Үүнд: компанийн дотоодын баримт бичгүүд (бодлогын баримт бичгүүд эрдслийн бүртгэл гэх мэт), хэвлэл мэдээлэл харьцуулсан судалгаа болон дотоодын оролцогч талуудын хэлэлцүүлэг хамаарна.


Эрэмбэлэх:

Судалгааны үр дүнг нэгтгэн цэгцэлж, хамгийн гол эрсдэлүүдийг тодорхойлон эрсдэлийн матрицад эрэмбэлсэн

Батлах:

Тодорхойлсон эрсдэлүүдийг баталгаажуулах зорилгоор хэлэлцүүлэг зохион байгуулан хамгийн чухал эрсдэлүүдийг энэхүү тайланд тусгав.

СЭДВҮҮД



Зарим талаараа чухал

Чухал ач холбогдолтой

Илүү чухал

Хамгийн чухал

Өндөр материаллаг эрсдэл	Тайлан дахь байршил
Орон нутгийн иргэдийг сонсох	Хуудас 36
Орон нутгийн иргэдийн хөгжил, хөрөнгө оруулалт	Хуудас 38
Хүрээлэн буй орчны удирдлага	Хуудас 44
Газар болон биологийн төрөл зүйлийн удирдлага	Хуудас 48
Усны менежмент	Хуудас 46
Уур амьсгалын өөрчлөлт	Хуудас 43
Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа	Хуудас 33
Ёс зүйтэй, ил тод байдлаар үйл ажиллагаа явуулах	Хуудас 24

Тогтвортой байдлын бодлого

Занаду компани тогтвортой хайгуул, хөгжлийн чиглэлээр манлайлагч нь байхыг эрмэлздэг. Энэ зорилгодоо хүрэхийн тулд бид өөрсдийн бизнесийн гол үнэ цэнд Тогтвортой байдлыг тусгаж өгсөн. Манай Тогтвортой Байдлын Бодлого нь ирээдүйд бидний өсөлт хөгжилтийн явцад бидэнд чиглэл болох дөрвөн гол чиглэлийг тусгасан байдаг.



Бид Монгол дахь түншүүддээ хариуцлагатай компани, сайн хөрш байхыг эрмэлздэг бөгөөд багаа аюулгүй байлгаж, хүрээлэн буй орчныг хамгаалах, орон нутагтаа дэмжлэг үзүүлэх арга замаар үйл ажиллагаагаа явуулж, хайгуул хийхийг зорьдог.

Засаглал

Занаду компани нь бизнесээ тогтвортой, ашигтай байлгах зорилгын хүрээнд бүх оффисууд, уурхайн талбарт бизнесийн ёс зүйн хэм хэмжээг баримталдаг.

Манай Төлөөлөн Удирдах Зөвлөл тус компанийн үйл ажиллагааны бүх хүрээнд хяналт тавих бүрэн эрхтэй байдаг.



Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуй Байгаль Орчны Хорооны дарга тогтвортой байдлын хяналт, засаглалыг хэрэгжүүлэх гол үүргийг хүлээдэг. Үүнд:

- Занаду компанийн үйл ажиллагаа явуулж буй бүх газруудад ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчныг хамгийн чухалд тооцох журмыг нэвтрүүлэх;
- Занаду компанийн үйл ажиллагаа явуулж буй газар бүрт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, хууль эрхзүй болон журмын шаардлагуудын нийцлийг хангах журмыг нэвтрүүлэх;
- Олон нийттэй харилцах харилцааг удирдах журмыг нэвтрүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй байгаль орчны бодит болон болзошгүй осол, зөрчлийг тайлагнах системийн хүрэлцээтэй байдал;
- Удирдлагын зүгээс осол зөрчлийн араас хийж гүйцэтгэж буй аюулгүй ажиллагааны шалгалт, засаж залруулах арга хэмжээ;
- ТУЗ-ийн баталсан зорилтын хэрэгжилт;
- Занаду компанийн үйл ажиллагаа явуулж буй газрын нутгийн иргэдийн эмзэг, мэдрэмтгий асуудлуудыг шийдвэрлэх зохистой боломжууд.

Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуй Байгаль Орчны Хорооны дүрмийн хуулбарыг манай вэб сайтаас авч болно. Аудит болон Эрсдэлийн Хороо нь бизнес, эдийн засаг, байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал болон бусад санхүүгийн бус эрсдэлүүдийг тодорхойлж, удирдахад ТУЗ-д тусладаг. Энэ Хороо нь Занаду компанийн байгаль орчны эрсдэлийн менежмент, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого журмын хэрэгжилтэд мөн хяналт тавьдаг болно.

Манай ТУЗ болон Удирдлага

Манай ТУЗ болон удирдлагын баг нь порфирын төрлийн зэс-алтны уурхайнуудыг амжилттай нээн илрүүлж, хөгжүүлж ирсэн туршлагатай хүмүүсээс бүрддэг.

ТУЗ



Ганбаяр Лхагвасүрэн
Монгол дахь Гүйцэтгэх захирал



Колин Мурхэд
ТУЗ-ийн Дарга, Удирдах Захирал



Мишэл Мусило
Захирал



Тони Пирсон
Захирал



Шаоян Шень
Захирал


Удирдлага



Мөнхсайхан Дамбийням
Үйл ажиллагаа хариуцсан захирал



Эндрью Стюарт
Хайгуулын дэд захирал



Мат Браун
Хайгуулын Ерөнхий менежер



Спэнсэр Коул
Санхүү хариуцсан захирал

Порфирын төрлийн зэс-алтны орд нээн илрүүлж, хөгжүүлж ирсэн туршлага



Монгол улсад
ажилласан туршлага




Хайгуулын ур
чадвар



Порфир орд
хөгжүүлсэн
туршлага



Арилжааны
болон
бизнесийн
ур чадвар



Ил тод, ёс зүйтэй ажиллах



Бид өөрсдийн бүх бизнесийг ил тод, ёс зүйтэй байдлаар хийж гүйцэтгэдэг. Энэ бол бид өөрсдийн ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, бэлтгэн нийлүүлэгчид болон төрийн байгууллага, олон нийттэй харилцахдаа шударга, үнэн зөв байна гэсэн үг юм.

Манай тогтвортой байдлын байр суурь манай Ёс Зүйн Дүрэмд, мөн манай Тогтвортой Байдлын Бодлогод тодорхой тусгагдсан байдаг. Манай бүх ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид болон бэлтгэн нийлүүлэгчид манай Ёс Зүйн Дүрмийг дагаж мөрдөх ёстой. Энэхүү Дүрэмд заавал дагаж мөрдөхөөр тусгагдсан шаардлагуудаас дурдвал:

- Ёс зүйтэй бизнес эрхлэх (авлига, хээл хахуулийг үл тэвчих)
- Нийлүүлэлтийн сүлжээ орчин үеийн боолчлолоос ангид байх (энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ одоо хийгдэж байна)
- Хөдөлмөрийн практик (ижил боломжоор хангах, ялгаварлан гадуурхах, дарамтлах, түрэмгийлэх зан авирыг үл тэвчих)
- Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуй
- Олон нийт ба байгаль орчин



100%

Ажилтнууд авлига, хээл хахуулийн
эсрэг бодлогыг дагаж мөрддөг



Хууль тогтоомж, бодлого болон журам

Занаду Майнз компанийн ТУЗ нь АХБ-ийн Компанийн Засаглалын Зарчим, Зөвлөмж (АХБ Зааварчилгаа)-д заасан компанийн засаглалын заавар, зөвлөмжүүдийг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг.

Бид компанийхаа байр суурийг Ёс зүйн дүрэм болон Тогтвортой байдлын бодлогодоо тодорхой тусгасан. Манай бүх ажилтан, гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид манай ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх ёстой ба доорх зүйлсийн хүрээнд заавал дагаж мөрдөх ёстой шаардлагууд орсон байдаг:

- Ёс зүйтэй бизнес (хээл хахууль, авлигын эсрэг);
- Хөдөлмөр эрхлэлтийн зарчим (тэгш боломж, ялгаварлан гадуурхалгүй, дарамтлах, доромжлох зан үйлээс ангид байх гэх мэт);
- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдал;
- Олон нийт ба хүрээлэн буй орчин

Ёс зүйн дүрмийн дагуу Занаду компани нь авлига, хээл хахуулийн эсрэг бодлогын (манай вэб сайтаас үзэх боломжтой) хүрээнд бизнесийн ёс суртахууныг баримталдаг. Энэхүү Бодлогын зорилго нь Занаду компанийн оролцогч талуудын

ашиг сонирхол, компанийн нэр хүндийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, Занаду компани болон түүний хяналтад байдаг байгууллагуудын (Занаду эсвэл Компани) хээл хахууль, авлигын талаарх байр суурийг тодорхойлдог.

Энэ нь Занаду компанийн бизнесийг ёс зүйтэй, шударгаар явуулах амлалтыг сахин биелүүлэхэд компанид болон компанитай хамтран ажилладаг хүн бүрийн үүрэг хариуцлага гэж тодорхойлсон байдаг. Энэхүү бодлого нь хээл хахууль, авлигын асуудлыг хэрхэн таних, хэрхэн шийдвэрлэх талаар мэдээлэл, зааварчилгааг өгдөг.

Энэхүү бодлого нь Занаду компанийн бүх удирдлага, ажилчид, гэрээлэгч, төлөөлөгчид, зөвлөхүүд болон Занаду компанийн нэрийн өмнөөс бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг эсвэл Занаду компанийн бүтээгдэхүүнийг түгээгч гуравдагч этгээдэд (нийлүүлэгч, борлуулагч, зөвлөх гэх мэт) бүгдэд үйлчилнэ.

Авлига, хээл хахуулийн эсрэг бодлогын гол зарчмууд:

Занаду компани нь бизнесийг ёс зүйтэй, шударгаар үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Занаду нь авлига, хээл хахуулийн эсрэг хатуу соёлыг төлөвшүүлэхийн төлөө ажилладаг. Занаду компани нь гуравдагч этгээдтэй харилцахдаа хамгийн дээд түвшний шударга байдлыг баримталдаг.

Занаду компани нь дэлхийн зах зээлд хүчтэй өрсөлдөгчийн хувиар хээл хахууль болон бусад авлигын үйлдэлгүйгээр оролцохыг эрмэлздэг.

Занаду компани нь ажилчдынхаа болон аливаа гуравдагч этгээдийн хээл хахууль, авлигын үйлдлийг үл тэвчдэг ба тус бодлогыг зөрчсөн аливаа үйлдлийг ноцтой хэрэг гэж үзэж, хөдөлмөрийн болон бусад гэрээг цуцлах зэрэг сахилгын шийтгэл ногдуулдаг.

Занаду орчин үеийн боолчлол, хөдөлмөрийн мөлжлөгийн асуудалд нухацтай хандаж, нийлүүлэлтийн сүлжээнд ийм зүйл тохиолдохгүй байхын тулд арга хэмжээ авдаг.

Бид өрөмдлөг, геофизикийн судалгаа, үндсэн шинжилгээний үйлчилгээгээ Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн урт хугацааны харилцаатай Монгол Улсын ханган нийлүүлэгч байгууллагуудаас авдаг. Цаашид Занаду компани ханган нийлүүлэгчидтэйгээ тэдний нийлүүлэлтийн сүлжээг ойлгохын тулд үргэлжлүүлэн хамтран ажиллаж, орчин үеийн боолчлолын эрсдлийг бууруулах, энэ талаарх ойлголтыг хөгжүүлэхэд хамтран ажиллах болно.

Ёс суртахуунтай бизнес эрхлэхийн зэрэгцээ бид аль болох гол оролцогч талуудтайгаа шууд ил тод аргаар харилцахыг хичээдэг. Дээрх аргуудаас дурдвал: нүүр тулсан хэлэлцүүлэг уулзалт; зохицуулалтын тайлан; ажилчдад болон иргэдэд зориулсан танилцуулга уулзалт; газар дээр очиж уулзаж танилцах; гэрээ хэлцэл; салбарын уулзалт болон арга хэмжээ зохион байгуулах зэрэг орно.

Занаду Майнз компанийн ТУЗ нь АХБ-ийн Компанийн Засаглалын Зарчим, Зөвлөмж (АХБ Зааварчилгаа)-д заасан компанийн засаглалын заавар, зөвлөмжүүдийг дагаж мөрдөх үүрэг хүлээдэг.

Дүрмүүд	Байгууллагын бодлого	Засаглал
<u>Удирдах Зөвлөлийн Дүрэм</u>	<u>Ёс зүйн дүрэм</u>	<u>Үндсэн хууль</u>
<u>Нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо</u>	<u>Авлига болон хээлийн хахуулийн эсрэг бодлого</u>	<u>Компанийн Засаглалын Мэдэгдэл</u>
<u>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны хороо</u>	<u>Тасралтгүй байх зарчим ба хувьцаа эзэмшигчдийн харилцааны бодлого</u>	<u>Ажилтны Хувьцаа Хөтөлбөр</u>
<u>Аудит, эрсдлийн хороо</u>	<u>Эрсдэлийн удирдлагын бодлого</u>	
	<u>Үнэт цаасны арилжааны бодлого</u>	
	<u>Тогтвортой байдлын бодлого</u>	
	<u>Уур амьсгалын өөрчлөлтийн бодлого</u>	
	<u>Мэдээлэгчийн бодлого</u>	
	<u>Хүний эрхийн бодлого</u>	

Үнэ цэнийг бүтээж, бүх оролцогч талуудын идэвх оролцоог хангах

Оролцогч талуудын оролцоо

Манай гол оролцогч талуудын оролцоо нь тус компанийн бизнес үйл ажиллагаа, мөн манай бизнес үйл ажиллагааны нөлөөнд өртсөн хүмүүсийн амьдралын хэв маягийг бэхжүүлж байдаг

Бид ил тод, нээлттэй харилцан ярилцаж, бусдын байр суурийг хүндэтгэх замаар харилцан ашигтай үр дүнд хүрэх харилцаа тогтоох, уг харилцааг цааш үргэлжлүүлэн сайжруулах үр дүнтэй оролцоо, зүтгэл хэрэгтэй гэдгийг ойлгодог. Оролцогч талуудыг сонгох үндэслэл нь тэдгээр хүмүүс Занаду Компанийн үйл ажиллагааны нөлөөнд хэр хэмжээгээр өртсөн, мөн тэдгээр хүмүүс Занаду Компанид хэр хэмжээний нөлөөтэй байхаас хамаарах ба гаргаж буй шийдвэр нь бусад оролцогч талуудын бүлгүүдэд хэр хүрч байгаагаас хамаарна.

Занаду нь гол оролцогч талуудын бүлгүүдтэй тогтмол, иж бүрэн харилцдаг. Дараах хүснэгтэд эдгээр бүлгүүд, тэдний ашиг сонирхолтой бид хэрхэн харилцдаг, ямар давтамжтай харилцдагийг харуулав. Бид энэ харилцааг хөгжүүлэх, авч явах үүрэг бүхий хүмүүсийг ажиллуулдаг. Манай бизнесийн болон байршлын онцлогийг харгалзан бид орон нутгийн иргэд, төрийн байгууллагуудтай харилцах харилцаагаа онцлон эрхэмлэдэг бөгөөд ингэснээр бид тэдгэр хүмүүсийн байр суурийг ойлгож, мөн өөрсдийн үйл ажиллагааны талаар тэдгээр хүмүүст үр дүнтэй мэдээлэл өгч ажилладаг.



Оролцогч Бүлгүүд	Оролцогчийн Төрөл	Оролцооны Арга	Оролцогч талуудын сонирхол
Хувьцаа эзэмшигчид	Хувьцаа эзэмшигчид, шинжээчид	- Улирлын, жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан - Вэб хуудас, и-мэйл, хөрөнгө оруулагчдын мэдээлэл, нүүр тулсан/ биечилсэн уулзалтууд - Зах зээлийн мэдээлэл - Жил тутмын ерөнхий уулзалт - Салбарын хурал - Биечилсэн уулзалт	- Аюулгүй ажиллагааны гүйцэтгэл - Хайгуулын ажлын үр дүн - Хөгжлийн төлөвлөгөө - Гүйцэтгэлийн үнэлгээ - Орон нутгийн харилцаа хамтын ажиллагаа - Санхүүгийн гүйцэтгэл - Хувьцааны үнэ
Үндсэн болон Гэрээт ажилчид	Удирдлага, үндсэн болон гэрээт ажилчид	- Ажилтнуудын мэдээлэл, - И-мэйл, олон нийтийн арга хэмжээ, мэдээллийн самбар, ажлын зааварчилгааны уулзалт, ажлын гүйцэтгэлийн уулзалт, - Нийтийн уулзалт - Шүгэл үлээх үйлчилгээ - Удирдлага ажилтнууд, багийн шууд харилцаа	- Үйл ажиллагааны гүйцэтгэл - Аюулгүй байдал, байгаль орчны биелэлт - Ажилтны оролцоо - Ажилтны хувь хүний хөгжлийн боломжууд
Орон нутгийн иргэд	Орон нутгийн иргэд, олон нийт, газар эзэмшигчид	- Орон нутгийн харилцаа хариуцсан багийн томилолт - Орон нутгийн иргэдтэй хийх уулзалт - Сайт аялал - Орон нутгийн иргэдийн санал сэтгэгдлийг удирдлагад тогтмол танилцуулах - Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа	- Орон нутгийн иргэдтэй хамтын ажиллагаа, үзүүлэх нөлөө - Хүрээлэн буй орчинд нөлөөлөх байдлын судалгаа - Орон нутгийн дэд бүтэц, жижиг бизнест хувь нэмэр оруулах - Газар ашиглалт
Ханган нийлүүлэгчид	Орон нутгийн болон орон нутгийн бус ханган нийлүүлэгчид	- Зах зээлд тулгуурласан арга барил - Нээлттэй, нүүр тулсан шууд харилцаа, хамтын ажиллагаа - Гүйцэтгэлийн тогтмол уулзалт - Гэрээ хэлцэл	- Урт хугацааны хамтын ажиллагаа - Орчин үеийн боолчлолоос ангид нийлүүлэлт
Засгийн Газар	Монголын үндэсний бүс нутгийн, орон нутгийн төрийн байгууллага, Австралийн засгийн газар	- Нээлттэй, нүүр тулсан шууд харилцаа, хамтын ажиллагаа - Жилийн эцсийн тайлан, вэб хуудас, - и-мэйл, гомдол санал, аудитын шалгалт - Зохицуулалтыг хангах, хэрэгжүүлэх - Орон нутгийн чухал асуудлуудад шууд харилцан хамтран ажиллах - Салбарын удирдлагын оролцоо	- Роялти, тусгай зөвшөөрлийн төлбөр - Аюулгүй ажиллагааны гүйцэтгэл - Ажил олголт - Хууль эрхзүй, зохицуулалтын шинэчлэл сайжруулалт - Байгаль орчны удирдлага, нөхөн сэргээлт
Салбар	Уул уурхай, хайгуулын салбар, бизнесийн болон мэргэжлийн байгууллага, холбоо, орон нутгийн болон бүс нутгийн бизнесийн байгууллага, холбоод	- Уул уурхай, хайгуулын чухал асуудлууд бодлогын талаарх уулзалт, хэлэлцүүлэг, тайлан - Тайлан, нүүр тулсан биечилсэн уулзалтууд, танилцуулга, хамтын ажиллагааны гэрээ хэлцэл	- Хүрээлэн буй орчны нөлөөлөл, - Аюулгүй ажиллагааны гүйцэтгэл - Сэтгэлзүйн эрүүл мэнд
Төрийн бус байгууллага	Байгаль орчны, орон нутгийн иргэдийн, уул уурхайн салбарын	- Уулзалт, и-мэйл - Хамтын ажиллагааны боломжийг эрж хайх	- Орон нутгийн иргэд болон байгаль орчин, хүрээлэн буй орчны нөлөөлөл - Авлигагүй, нээлттэй ил тод төлбөр тооцоолол
Боловсрол	Дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагууд	- Хуралд оролцох - Уулзалт, тайлан, биечилсэн хэлэлцүүлэг	Орон нутгийн иргэдийг сурч боловсрох боломжийг дэмжих

Манай хамт олон



Бизнес амжилтанд хүрэхийн тулд хүмүүст хөрөнгө оруулах шаардлагатай байдаг. Иймд бид олон талт ажлын байрыг хөгжүүлэх замаар өөрсдийн хүмүүсийн боломж бололцоог бүрэн дүүрэн ашиглахыг зорьдог.

Бидний эрхэм зорилго орон нутгийн авъяастнууд, төслийн менежерүүд болон туршлагатай мэргэжилтнүүд эдгээр гайхалтай төслүүд дээр хамгийн аюулгүй, үр дүнтэй арга хэлбэрээр хамтран ажиллаж болох орчныг бүрдүүлэхэд оршино. 2022 оны календарийн жилд бид бүх үйл ажиллагааны чиглэлд ажиллаж буй эмэгтэй, эрэгтэй ажилтнуудын чадварыг сайжруулах чиглэлээр 384 цагийн сургалт хийсэн байна. Үүнээс гадна, Монгол Улсад ажиллаж буй манай ажиллах хүчин 2022 оны календарийн жилд хөгжлийн сургалт, үнэлгээнд 100% хамрагдсан байна. Бид эдгээр тоон үзүүлэлтүүдийг жил бүр хянаж, ажиллах соёл, ёс зүйг нэмэгдүүлэх, авъяаслаг ажилтнуудыг татах, олон төрөлт мөн олон талт нөхцөл байдлыг хангах чиглэлээр нэмэлт арга замуудыг гаргаж ирэхийг эрэлхийлэх болно.

Манай компанийг шинэ орд газруудыг нээн илрүүлэх, үнэ цэнийг бүтээх арвин туршлагатай хайгуул, уул уурхайн салбарын мэргэжилтнүүд удирдан ажиллуулдаг. Бид өөрсдийн Тогтвортой Байдлын Бодлогыг

тасралтгүй сайжруулахыг эрмэлздэг бөгөөд уг Бодлогод ажилтнууд болон тус компанийн үйл ажиллагаа явуулж буй орчны ард иргэдийг хайрлан хамгаалах бидний үүргийг чухалчлан дурдсан байдаг. Занаду компани багийн гишүүдээ сонсож, тэднээс суралцаж, тэдний ажлыг бид хэрхэн сайн дэмжиж болох талаар санал бодлыг нь хэрэгжүүлж ажилладаг. Энэ тусалцааг санал болгосноор бид ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгчид амжилтанд хүрэх бүрэн боломжтой гэсэн ойлголттойгоор ажиллах нөхцлийг бүрдүүлдэг. Занаду компани ажилтнууд болон гэрээт гүйцэтгэгч нарт цаашид үргэлжлүүлэн хөрөнгө оруулах бөгөөд ингэснээр бидэнтэй цаашид хамтран ажиллах, бизнесийн тогтвортой хөгжлийг хангахыг зорьдог. Дараах хүснэгтэд бид энэ жилийн ажилтнуудын тоо өрөмдлөгийн үйл ажиллагаа багассаны улмаас өнгөрсөн жилтэй харьцуулахад буурсан байгааг харуулав.

	2021	2022
Монголд ажиллаж буй Үндсэн болон Гэрээт ажилчдын нийт тоо	175	49
Үндсэн ажилчдын тоо	89	29
Гэрээт ажилчдын тоо	86	20
Эмэгтэй ажилчдын хувь	25%	14%

Бидний эрхэм зорилго
орон нутгийн авъяастнууд,
төслийн менежерүүд болон
туршлагатай мэргэжилтнүүд
эдгээр гайхалтай төслүүд дээр
хамгийн аюулгүй, үр дүнтэй
арга хэлбэрээр хамтран
ажиллаж болох орчныг
бүрдүүлэхэд оршино.”



Эмнэлгийн чанартай тусламж үйлчилгээ авах боломж


**Занаду Компани өөрсдийн сонголтоор Цогтцэций эмнэлэгтэй
түншлэн ажиллаж байна.**

Тус компанийн үйл ажиллагаа явуулж буй газар нутагт хүн ам сийрэг суурьшдгийг харгалзан үзвэл Хармагтай төслийн талбайгаас 100км хүртэлх зайд Цогтцэций эмнэлэг байршиж байгаа нь аливаа эрсдэл, онцгой байдал үүссэн тохиолдолд манай хүмүүст тусламж үзүүлэх боломж байна гэсэн баталгааг олгодог. Тус эмнэлэг нь 7300 гаруй нутгийн оршин суугчдад

эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхээс гадна тус бүс нутгийн хүрээнд эмчилгээ, үйлчилгээний чанараар тэргүүлдэг тул энэ түншлэлийн хүрээнд манай бүх ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид төдийгүй тус бүс нутгийн ард иргэд чанартай үйлчилгээ авах боломж бүрдэх юм.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах



Занаду компани бүх хүмүүст эрүүл, аюулгүй ажиллах орчинг бүрдүүлэхийг зорьдог. КОВИД-19 цар тахал эхлэснээс хойш бүх ажилтнууд компанийн дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн иж бүрэн оношлогоо хийлгэж, улмаар компанийн дэмжлэгтэй эрүүл мэндийн даатгалын хөтөлбөрийн дагуу зохих эмчилгээ, үйлчилгээг авсан болно

Занаду компанийн ашигладаг өндөр үр дүнтэй хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн систем болон хүний нөөцийг хадгалах хэрэгсэл нь бүх ажилтнуудыг урт хугацааны осол гэмтлээс хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Осол болоход дөхсөн тохиолдлуудыг тайлагнахтай холбоотой соёлыг хөгжүүлэхэд анхаарах замаар бид ноцтой осол гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр амжилттай ажиллаж байна. 2022 оны календарийн жилд бид 52,000 гаруй хүн*цаг ажил гүйцэтгэснээс хөдөлмөрийн чадвар алдахад хүргэсэн осол зөрчил 0, хүний амь нас алдахад хүргэсэн осол зөрчил 0 гэсэн амжилттай ажилласнаа дурдахад таатай байна. Үүнд мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн тоо мөн орно.

Занаду компанийн ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид аюулгүй, өөрсдийн эрүүл мэндэд эрсдэлгүй орчинд ажиллаж буй гэдгээ баталгаажуулах үүднээс хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль тогтоомж, Занаду компанийн бодлого журмыг дагаж мөрдөж ажиллах шаардлагатай. Аюулгүй ажиллагааны үр дүнтэй систем нэвтрүүлснээр үйл ажиллагааны үр өгөөж, хайгуулын үйл ажиллагааны үр дүн сайжрах боломжтой гэдэгт бид итгэдэг. Үүний дүнд бид төслийн хүрээнд тохиолдож болзошгүй өндөр эрсдэлтэй

үйл ажиллагаануудад тусгайлан нийцсэн эрсдэлийн бүртгэлийг бий болгосон. Эдгээр эрсдэлийн бүртгэл нь дунд шатны удирдлагууд гол хариуцлагыг хүлээж, үйл ажиллагааны эрсдэлийг арилгахад онцгойлон ач холбогдол өгдөг. Манай үйл ажиллагаа явуулж буй талбайнууд дахь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн бодлого, сургалтууд нь Монгол хэл дээр хийгддэг болно.

Манай аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн байр суурь Тогтвортой Байдлын Бодлогод тусгагдсан байдаг. Энэхүү Бодлогоор дамжуулан бид дараах зорилтуудыг хэрэгжүүлэхийг зорьдог. Үүнд:

- Аюулгүй, эрүүл хөдөлмөрийн орчинг бий болгох үүднээс бүх оролцогч талуудын оролцоог хангах.
- Хүн бүр аюулгүй, үнэ цэнтэй, дэмжлэгтэй гэдгээ мэдэрдэг, бүгдийн оролцоог хангасан олон талт ажлын байрыг бий болгох.
- Ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, бэлтгэн нийлүүлэгчид болон ард иргэдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах.
- Занаду компанийн Тогтвортой Байдлын Бодлогыг манай вэб сайтаас үзэх боломжтой.



Ажилтнуудын өсөлт, хөгжилтийг дэмжих

Занаду компанийг тогтвортой байдлыг хангагч ажил олгогч болгодог нэг гол хүчин зүйл нь бид ажилтнуудын мэргэжлийн өсөлтийг хувь хүний хөгжилтэй нэгтгэж авч үздэгт оршино. Үүний жишээг манай компанид 2006 онд геологичоор ажилд орсон Ганцэцэгийн туршлагаас харж болно

Ганцэцэг нь тус компанид ажиллах хугацаандаа төрийн байгууллагуудтай харилцах, уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой дүрэм журмын нийцлийг хангах зэрэг олон үүргийг гүйцэтгэж ирсэн. Занаду компани түүнийг геологич байхаас эхлээд тусгай зөвшөөрлийн комплаенс хариуцсан чухал албан тушаалд очиход нь туслаж дэмжиж байсан гэдгийг, компанид болон энэ салбарт илүү чухал үүрэг гүйцэтгэх боломж олгож, компани болон түүний гадны оролцогч талууд хоорондын холбоог хангах чиглэлээр ажиллах боломжийг олгосон гэдгийг тэр онцолдог.

“Геологич хүний хувьд би Монгол Улсын ашигт малтмалын асар арвин нөөц бололцоог нээн илрүүлэх боломжид татагдсан. Миний эргэн тойронд бие биедээ туслах чин хүсэл

эрмэлзэлтэй хүмүүс ажилладаг. Энэ компани намайг геологичоос төрийн байгууллагуудтай ажилладаг тусгай зөвшөөрлийн комплаенс хариуцсан чухал хүн болгож өсгөж хөгжүүлэхэд анхаарч ажилласан”.

Одоо Ганцэцэг нь тус компанид чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ тус компанийн ирээдүй, үйл ажиллагааны чиглэл, ялангуяа Хармагтай хөтөлбөр түүнийг цаашид мэргэжлийн хувьд өсөн дэвших боломж олгож байгааг онцолсон юм.

“Занаду компани Монгол Улсын геологи, уул уурхайн салбарт томоохон хувь нэмэр оруулж байгаад баяртай байдаг. Би Хармагтай ордыг ашиглалтанд оруулж, зэсийн олборлолтыг эхлүүлэх шийдвэрийг хамгийн их хүлээж байна.”



Карьерын зорилтыг дэмжих

Батцэнгэл нь 2017 онд Занаду компанид хайгуулын ажил хийх хүсэл сонирхолтой туслах геологичоор ажилд орсон.

Батцэнгэл нь 2017 онд Занаду компанид хайгуулын ажил хийх хүсэл сонирхолтой туслах геологичоор ажилд орсон. Хармагтай болон Улаан Уул зэрэг төслүүд дээр тэргүүн шугамд ажиллаж байх явцдаа тэрээр геологи хайгуулын олон төрөл зүйл арга аргачлал, үүн дотор каротаж, өгөгдөл оруулах, мөн өндөр технологийн скан төхөөрөмж ажиллуулах зэрэг өргөн туршлага хуримтлуулсан байна.

Занаду компани ажилтнуудаа хөгжүүлж, хайгуулын ажлыг шинжлэх ухаанч байдлаар хэрэгжүүлж, өөрийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх өргөн боломжуудыг олгодогт тэрээр талархдаг.

“Занаду компани ажилтнуудаа компанийн үнэ цэн гэж үздэг бөгөөд тэдний хувийн хөгжил, нийгмийн байр суурийг анхаарч авч үздэг. Миний хувьд энэ компани шинжлэх ухаанч байр сууринаас ажилладаг нь надад хайгуулын ажилд ховорхон ашиглагддаг тоног төхөөрөмж, геологийн баримт бичиг зэрэг олон зүйлтэй танилцахад их дэм болдог.”

Батцэнгэлийн хувьд мэргэжилдээ цаашид илүү мэргэших хувийн зорилго тавьсан бөгөөд Занаду компанийн цаашдын өсөлт хөгжилт, мөн тус компани дотор өөрөө өсөж дэвшинэ гэдэгтээ итгэлтэй байна.

2022-2023 оны Оюутны Тэтгэлгийн Хөтөлбөр



Бид нутгийн иргэдийг анхаарч халамжилдаг

Нутгийн ард иргэдийг бид анхааралдаа авч, тэдэнд эерэг үр нөлөө үзүүлэхийг зорьдог. Занаду бол хариуцлагатай компани бөгөөд өөрсдийн ажиллаж, амьдарч буй орчны ард иргэдийг идэвхтэй дэмждэг билээ.

Манай дотоод болон гадны баг хамт олнууд компанийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө, дундуур болон дараа нь компанийн шилдэг практик туршлагыг нэвтрүүлэх бидний хүсэл эрмэлзлийг хангаж ажиллана гэдэгт бид итгэлтэй байдаг. Манай компани өөрсдийн хүмүүсийг нийгэм олон нийтийн хэрэгцээг хангах үйл хэргийг идэвхтэй явуулахад нь дэмжлэг үзүүлдэг. Өнгөрсөн дөрвөн жилийн туршид бид орон нутгийн иргэдтэй тогтмол холбоотой байж тэдний хүсэл сонирхлыг сонсож, үүсэн гарч болзошгүй аливаа гомдол саналуудыг шийдвэрлэж ирсэн билээ. Бид аливаа гомдлыг шийдвэрлэх шуурхай арга хэмжээ авч, харилцаагаа хөгжүүлэх чиглэлд ажилладаг. Цөөн тохиолдолд асуудал үүссэн үед бид нутгийн иргэдийг манай орон нутгийн харилцаа хариуцсан менежертэй уулзаж, өөрсдийн санал гомдлыг бичгээр гарган өгөхийг хүсдэг ба үүний араас манай баг нэн даруй арга хэмжээ авч ажилладаг. Үүнээс гадна, бид орон нутгийн иргэдээс санал гомдол хүлээн авах шуурхай утас нээн ажиллуулж байна.

Бидний зорилго бол цаашид шууд харилцаа холбооны энэ хэлбэрийг үргэлжлүүлэн

хөгжүүлэх явдал юм. Бид 2022 оны календарийн жилд нийт 4 олон нийтийн гомдол хүлээж авсан ба хамтарсан, шууд арга хэмжээ авах замаар эдгээр асуудлуудыг амжилттай шийдвэрлэсэн байна.


Манай гол анхаарах чиглэлүүд:

- Ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчид, бэлтгэн нийлүүлэгчид, нутгийн ард иргэдийн хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах.
- Зөв хүмүүсийг татах, авч үлдэх үүднээс бидний ажиллаж буй нутгийн ард иргэдийг төлөөлөх ажиллах хүчнийг бүрдүүлэх.
- Нутгийн иргэдийн эрх, хүсэл тэмүүллийг хүндэтгэх, дэмжих замаар тэдэнд үйл ажиллагааны үр ашгийг хүртээх.
- Бидний үйл ажиллагааны нөлөөнд өртсөн хүмүүсийн соёлын өв, зан заншил, уламжлалыг хүндэтгэх.
- Нутгийн удирдлага, иргэдийн санал бодлыг шийдвэр гаргалтандаа тусгаж, тэдэнтэй нээлттэй, ил тод байдлаар тогтмол харилцах.





Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих



Орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил нь Занаду компани болон манай оролцогч талуудад маш чухал ач холбогдолтой билээ.

Алслагдсан газар нутагт нутгийн ард иргэдийг дэмжих, хөгжүүлэх, тэдний богино хугацааны хэрэгцээг хангах, мөн урт хугацааны өсөлтийг хангах олон боломжууд байгаа гэдгийг бид ойлгож байна.

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд бид орон нутгийн засаг захиргаа, хамт олонтой хамтарч тухайн бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих чиглэлээр олон санал санаачлага гаргаж ажиллав. Эдгээр санаачлагуудын нэг нь өрх толгойлсон эхчүүдийн ажиллуулдаг орон нутгийн оёдлын цехтэй хамтарч ажиллах байсан ба ажилтнуудын ажлын хувцаснаас эхлээд тоног төхөөрөмжийн хучлага хүртэл олон янзын бүтээгдэхүүн захиалан хийлгэсэн болно. Орон нутгийн иргэдийг ажилд авахын үр дүнд бидний орон нутгийн харилцаа сайжирсан бөгөөд цаашид энэ мэт хамтын ажиллагааг

үргэлжлүүлэн эрхлэх сонирхолтой байна.

Занаду компанийн зүгээс орон нутгийн нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлээр гаргасан бусад санал санаачлагуудаас дурдвал:


Соёл, наадмын арга хэмжээнүүд, үүн дотор хурдан морины уралдаан, орон нутгийн улирлын болон шашны баяр наадмуудыг дэмжиж ажилласан ба 80 гаруй өрхийн 200 гаруй хүмүүс оролцов.

Өвлийн хүнд хэцүү цагийг хохирол багатай даван туулахад зориулж малын тэжээл хандивлав.

Орон нутгийн эмнэлэгт эм тариа, вакцин хадгалах хөргүүр зэрэг эмнэлгийн тоног төхөөрөмж хандивлаж, шарил хадгалах шинэ байр барихад нь тусалцаа үзүүлэв.



Нутгийн ард иргэдэд гүний худаг гаргаж өгөв



Говь нутагт ус маш хомс бөгөөд маш чухалд тооцогддог

Нутгийн ард иргэд ахуйн хэрэгцээгээ хангах, мал сүргээ маллахдаа уснаас хамааралтай амьдардаг ба энэ бүс нутгийн амьдралд ус маш чухал үүрэгтэй юм. Нутгийн ард иргэд гүний уснаас хамааралтай амьдардгийг, энэ нь ямар том сорилт, даваа болдгийг Занаду компани ойлгосон тул бид өрмийн туслан гүйцэтгэгч нартай хамтран төслийн талбай бүрт 2-3 жил тутамд 100м гүнтэй гүний усны худгуудгийг өрөмдөж сайн чанарын усаар нутгийн ард иргэдийг хангах, нутгийн малчид олон нийтэд дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлсэн юм.

Занаду компани усны чанарыг тодорхойлох үүднээс гидрогеологийн судалгаа, хэмжилт хийж, усыг шахаж гаргах үүднээс дизель генератор, насос олгож эдгээр худгууд зохих стандартын дагуу, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс засвар үйлчилгээ хийхэд нь тусалцаа үзүүлж ажилладаг. Бид 2022 оны хугацаанд Хармагтай бүсэд 900 гаруй хэмжилт судалгаа, Улаан Уул бүсэд 200 гаруй хэмжилт судалгаа хийсэн байна.



Орон нутгийн боловсролын дэд бүтцийг барьж байгуулав



Манай компани өөрийн үйл ажиллагаа явуулж буй орон нутагт амьдарч буй хүмүүсийн боловсрол, эдийн засгийн хөгжлийг дэмжих үүднээс орон нутгийн ажлын төсвийг зарцуулах чиглүүлэхийг эрмэлздэг.

Бидний хийж гүйцэтгэсэн гол ажлуудаас дурдвал Хармагтай дүүргийн орон нутгийн хоёр цэцэрлэгийн ангиудыг тохижуулж, засвар үйлчилгээ хийсэн. Эдгээр цэцэрлэгүүд нь тус бүр 3-5 насны 70 орчим хүүхдүүд хүлээж авдаг байна. Бид тус цэцэрлэгүүдэд шинэ анги гаргаж, тавилга, тоног төхөөрөмж, мөн тоглоом олгосон нь манай хамгийн залуу оролцогч иргэдийн хөгжилд тус дэм болох, цэцэрлэгийн тоног төхөөрөмж, олгож буй боловсролоор дамжуулан эцэг эхэд нь мөн дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Энэхүү ажлыг бид орон нутгийн захиргааны тодорхой дэмжлэгтэйгээр, нутгийн захиргаа болон ард иргэдтэй хамтран ажиллах замаар хэрэгжүүлсэн билээ.



Боловсролын туслалцаа, дэмжлэг үзүүлэх замаар нутгийн иргэдэд дэмжлэг




Занаду компани дунд боловсролын дэмжлэг болон компанийн дадлагын хөтөлбөрүүдээр дамжуулан ард иргэдтэй урт хугацааны хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлсээр байна.

Бид сургуулийн ширээнээс хөдөлмөрийн харилцаа руу шилжих залуучуудын боловсролд дэмжлэг үзүүлэх замаар нутгийн ард иргэдийн хөгжлийг хангахын ач холбогдлыг бүрэн ойлгодог. Ингэснээр залуу үеийнхэн өөрсдийн ур чадварыг хөгжүүлэх, боломжуудыг нээн гаргах, мөн орон нутагтаа буцаад тус дэм үзүүлэх боломжтой болох юм.

Жил бүр бид нутгийн оюутан залуус сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох замаар боловсролын дэмжлэг үзүүлдэг. Үүнд инженер, анагаах ухаан, нягтлан бодох бүртгэл, шинжлэх ухаан зэрэг төрөл бүрийн салбарын, олон их сургуулийн оюутнууд хамрагдах боломжтой юм.

2022 онд бид Хармагтай болон Улаан Уул төслийн нутгаас нийт 43 оюутанд их сургуульд суралцахад нь дэмжлэг үзүүлсэн нь 2021 оны тоотой харьцуулахад эрс өссөн үзүүлэлт болсон байна. Эдгээр оюутнуудад 15 их дээд сургуульд 10 мэргэжлээр суралцах боломж олгосон байна. Үүнээс гадна, бид уул уурхайн салбарт дадлага хийх, хөдөлмөр эрхлэх сонирхолтой залууст дадлага хийх боломж олгодог. Боловсролын салбарт оруулж буй бидний хөрөнгө оруулалт тухайн орон нутгийн эдийн засгийн хөгжил, ирээдүйд хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэдэг

2018-2022 онуудад олгосон нийт сургалтын тэтгэлгүүд



Өмнөговьд уул уурхай хөгжүүлэхэд нь Монгол Улсад дэмжлэг үзүүлэх

Манай төслүүд, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд Өмнөговь аймагт уул уурхай хөгжүүлэх Монгол Улсын Засгийн Газрын зорилтыг хэрэгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулна гэж үзэж байна

Манай Хармагтай төсөл бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед эхний 5 жилдээ жил бүр 40,000 тонн зэс, 100,000 унц алт үйлдвэрлэнэ. Мөн эхний 5 жилд 500 гаруй хүн бааз дээр ажиллах, улмаар олборлолтын төлөвлөгөөт тэлэлтийн дагуу түүнээс цааших хугацаанд 900 гаруй хүн ажиллах тооцоотой. Орон нутгийн оффис, Улаанбаатарт ажиллах хүмүүсийн тоог энэ тоонд оруулаагүй болно.

Монгол Улсын засгийн газар тус бүс нутгийн дэд бүтцэд томоохон хөрөнгө оруулж байгаа нь дэмжлэг болж байна.

Төмөр зам ба авто зам:

Сайншанд – Цогтцэций чиглэлд шинэ төмөр зам ашиглалтанд орсноор транс-Монголын

төмөр замтай холбогдож байна. Төмөр замын шугамыг дагаад шинэ авто зам ашиглалтанд орох ба Зүүнбаян, Цогтцэций-гээс өмнөд зүгт БНХАУ руу шинэ төмөр зам барих ажил үргэлжилж байна

Эрчим хүчний дэд бүтэц:

Шинэ Таван Толгой цахилгаан станцыг барьж байгуулж байна. Таван Толгой бүс нутаг руу нэмэлт цахилгааны шугам татагдах болно.

Зэс хайлуулах үйлдвэр:

Монгол Улсын засгийн газар Эрдэнэт үйлдвэрт 2025-2026 он гэхэд зэс хайлуулах үйлдвэр барихаар төлөвлөж байгаа ба Оюу Толгой уурхайд зэс хайлуулах үйлдвэр баригдах яриа хэлэлцээ үргэлжилж байна.



Өмнөговь аймгийн дэд бүтэц

Өмнөговь төмөр замд ашиглах галт тэрэг

Байгаль орчинд үзүүлэх одоогийн болон ирээдүйн нөлөөллийг бууруулах

Эрчим хүч бага зарцуулах технологи руу шилжих

Сэргээгдэх эрчим хүчний өсөлтийг хангах, үйлдвэрлэлийн олон салбаруудыг цахимжуулах замаар эрчим хүч бага зарцуулах технологи руу шилжихэд зэс чухал үүрэг гүйцэтгэнэ. Нар болон салхины эрчим хүчний технологиуд ашиглалтын бүрэн хугацааны туршид нүүрсээр ажилладаг цахилгаан станцын гаргадаг эрчим хүчтэй харьцуулахад ялгаруулдаг нүүрстөрөгчийн 1-4%, байгалийн хийн эх үүсвэртэй эрчим хүчний нүүрстөрөгчийн 3-9%-ийг ялгаруулдаг байна. Сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан автомашин зэрэг шинэ, шинэлэг технологийн хөгжлийн үр дүнд үүсэх цахилгаанжуулалт нийлээд гол үүрэг гүйцэтгэх ба үүний дүнд литиум, никель, кобальт, зэс зэрэг материалын эрэлтийг хэд дахин нэмэгдүүлэх болно.

Салхины болон Нарны эрчим хүч үйлдвэрлэхэд 1 МВт эрчим хүч тутамд 8,000кг орчим зэс шаардагдах бол уламжлалт технологиор цахилгаан үйлдвэрлэхэд ердөө 3-7 дахин их зэс шаардагддаг.

Зэсийг зөвхөн цахилгаан автомашины баттерейнд биш, үүнээс гадна мотор, инвертер/конвертер, кабель, дотоод цэнэглэх системүүдэд ашиглана. Цахилгаан автомашины дэд бүтцэд хэт хурдан цэнэглэх технологи, шугам сүлжээний хөрөнгө оруулалтад зэс чухал үүрэг гүйцэтгэнэ. Цахилгаан автомашины бусад металлуудаас ялгаатай нь цахилгаан автомашин бүр дэх зэсийн хэрэглээ цаашид нэмэгдэх ба баттерейн хүлээгдэж буй химийн технологийн хувьслын дүнд шаардагдах металлын хэмжээ 2030-2052 онуудад буурах хэдий ч зэс ашиглагдсаар

байх болно. Хэрэв цахилгаан машины эрэлт огцом нэмэгдэх тохиолдолд цахилгаан машины зэсийн эрэлт сэргээгдэх эрчим хүчний зэсийн эрэлтийг давж болзошгүй гэж бид үздэг. Мөн, зэсийн хүлээгдэж буй эрэлттэй харьцуулахад зэсийн нийлүүлэлт, шинэ зэсийн ордын нээлт хязгаарлагдмал байх магадлалтай байна. Зэсийн нийлүүлэлт хязгарлагдахад хүргэх олон хүчин зүйлс байгаагаас дурдвал:

- Зэсийн шинэ ордын төслийн тоо цөөрч байна
- Зэсийн агуулга буурч байна (Дэлхийн нөөцийн дундаж агуулга 1990-ээд оноос хойш хоёр дахин буурч ~0.5% Cu болсон байна.)
- Төсөл хэрэгжүүлэх хугацаа урт (зэсийн орд нээснээс хойш үйлдвэрлэлд хүрэх хугацаа одоо 10 гаруй жил байна)

Занаду Майнз компани үйлдвэрлэлийн шат руу шилжихэд бэлэн болсон, нэрийн хуудас болсон Хармагтай төсөл дэх зэсийн батлагдсан нөөцөөр дамжуулан эрчим хүч бага зарцуулах технологи руу шилжих шилжилтэд хувь нэмрээ оруулах зорилготой байна. Хармагтай орд нь 1.1 тэрбум тонн эрдэс, үүн дотор 3 сая тонн зэс, 8 сая унц алт байгаагаас 100 сая гаруй тонн нь өндөр агуулгатай бүсэд харьяалагдаж байгаа бөгөөд 2028-2057 онуудад 1.5 сая тонн зэс нийлүүлэх тооцоотой байна. Хармагтай төслийн урьдчилсан ТЭЗҮ 2023 онд эхэлсэн бөгөөд олборлолт эхлэх шийдвэр 2024 онд гарах хүлээлттэй байна.

Салхин цахилгаан станцын зэсийн хэрэглээ

3 мегаватт (МВт) чадалтай салхин турбинд 4.7 тонн хүртэл зэс ордог



Далайд баригдах салхин цахилгаан станц нь бусад салхин цахилгаан станцуудтай харьцуулахад 1МВт цахилгаан үйлдвэрлэхэд шаардагдах зэсийн хэрэглээ хавьгүй өндөр байдаг. Нийт зэсийн хэрэглээний 82% хүртэлх хувь нь зэс кабель шугамд хамаардаг байна

Нарны цахилгаан үйлдвэрлэх технологи дахь зэсийн хэрэглээ

Нарны цахилгаан үйлдвэрлэх технологийн зэсийн дундаж хэрэглээ 1МВт тутамд 5.5 тонн байна.

Өргөн хэрэглээ:



Халаалтын системүүд

Нарны эрчим хүчийг ус эсвэл агаарын халаалтын систем рүү шилжүүлэхэд



Цахилгаан шугам

Цахилгааныг дамжуулахад ашиглана



Кабель

Цахилгаан эрчим хүч эсвэл дохио дамжуулах зориулалттай тусгаарлагдсан бүлэг дамжуулагч

Эх сурвалж:

Байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг бууруулах



Занаду компани байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг бууруулах, энэ чиглэлээр салбарынхаа тэргүүлэгч нь байх үүднээс орчин үеийн, шинэлэг хайгуулын арга аргачлалыг ашигладаг.

Үүнд орчин үеийн геофизикийн судалгааны багаж хэрэгслийг ашиглан зорилгуудаа илүү сайн тодорхойлж, өрмийн цооногийн тоо, эрчим хүч, хүний нөөцийн зарцуулалтыг багасгах зэрэг болно.

Өрөмдлөгийн ажил эхэлмэгц, өрмийн цооног бүрээс хамгийн их хэмжээний өгөгдлийг гарган авахын тулд Занаду нь олон спекрт чөмгөн дээжний сканнерын дэвшилтэт технологийг ашигладаг. Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, химийн найрлага, геологийн бүтэц, геотехникийн болон геометаллургийн шинж чанарыг тодорхойлох үүднээс хиймэл оюун ухаан, машин сургалтыг мөн ашигладаг болно.

Энэхүү шинжилгээ нь өрөмдлөгийн ажлыг багасгаж, тогтвортой байдалд хамгийн бага нөлөө үзүүлэх хэлбэрээр, үр дүнтэй хайгуул хийх боломжийг олгодог.

Занаду компани хайгуулын төслүүдээ хайхаас эхлээд нарийвчилсан судалгааны үе шат хүртэл хөгжүүлэх явцад аюулгүй байдал, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, үр дүнг оновчтой болгох орчин үеийн, өндөр бүтээмжтэй технологи ашигласнаар ирээдүйн орчин үеийн үр бүтээлтэй уурхайг хөгжүүлэх боломжийг бий болгохыг зорьдог

Эрчим хүч болон нүүрстөрөгч ялгаруулалтын менежмент

Байгалийн баялагт түшиглэж үйл ажиллагаа явуулдаг компанийн хувьд бид байгаль орчныг хамгаалах хэрэгцээг тун сайн ойлгодог билээ. Бид мөн уур амьсгалын өөрчлөлт болон эрчим хүч манай бизнест ямар нөлөө үзүүлж болохыг бүрэн мэддэг. Бид энэхүү дэлхий нийтийн өмнө тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэх, түүнд дасан зохицох, үүний хүрээнд өөрсдийн үйл ажиллагаанд сэргээгдэх эрчим хүч ашиглах, нүүрстөрөгчийн өртгийн арилжаа хийх, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг тооцоолох сценари төлөвлөлт гаргах, өөрсдийн тогтвортой байдлын зорилтуудыг уур амьсгалд нийцүүлэн тогтоох замаар өөрсдийн хувь нэмрийг оруулах үүрэг хүлээдэг. Эрчим хүч бол анхааралтай

судлан авч үзвэл зохих дахин давтагддаг процесс юм. 2022 оны календарийн жилд манай компани өөрийн үйл ажиллагаанаас 183 тонн нүүрстөрөгчийн давхар исэлтэй дүйх бүтээгдэхүүн (CO₂e) ялгаруулсан байна. Энэ нь манай 1 болон 2-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарлуудын нийлбэр юм. Манай 1-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарал нийт 179 тонн CO₂e болсон нь тээврийн автомашинуудын дизель түлшний хэрэглээнээс үүдсэн байна. 2-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарал нийт 4.6 тонн CO₂e болсон нь манай барилга байгууламжууд дахь цахилгааны хэрэглээнээс үүссэн байна. Манай нүүрстөрөгчийн ялгарлын мэдээлэл дараах байдалтай байна:

1-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарал *	2-р зэрэглэлийн нүүрстөрөгчийн ялгарал *
179.24	4.65 тонн CO ₂ e

*Нүүрстөрөгчийн ялгарлын тооцооллын аргачлал: Үйл ажиллагааны хяналтын хүрээнд Хүлэмжийн Хийн Протокол. Бизнес, Эрчим хүч, Үйлдвэрлэлийн Стратегийн Газрын нүүрстөрөгчийн ялгарлын хүчин зүйлсийг ашиглан тооцоолсон. Энд ашигласан тоон мэдээлүүд нь төлөөлөх чанартай бөгөөд байгууллагын суурь тооцоолол болохгүй. Бид ирэх хоёр жилийн хугацаанд суурь судалгааг хийж гүйцэтгэхийг зорьж байна.

**Нүүрстөрөгчийн ялгарлын тооцооллын аргачлал: Үйл ажиллагааны хяналтын хүрээнд Хүлэмжийн Хийн Протокол. Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ийн суурь конвенц (УАӨТНҮБСК)-ийн нүүрстөрөгчийн ялгарлын хүчин зүйлсийг ашиглан тооцоолсон. Энд ашигласан тоон мэдээлүүд нь төлөөлөх чанартай бөгөөд байгууллагын суурь тооцоолол болохгүй.



УСНЫ МЕНЕЖМЕНТ



Ус бол Монгол Улсын үнэт баялаг гэдгийг бид бүрэн ойлгож, усыг хариуцлагатайгаар ашигладаг. Занаду компани үйл ажиллагаандаа, ялангуяа өрмийн машины хэрэгцээнд өөрсдийн гаргасан үйлдвэрлэлийн худгийн усыг ашигладаг

2022 оны календарийн жилд бид 6290м³ буюу 6.293 мегалитр усыг хайгуулын зорилгоор ашигласан байна.

Бид өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй нутгийн ард иргэдийг ус олборлох үйл ажиллагаанд үр дүнтэй оролцуулж бидний үйл ажиллагаа тэдний гүний ус ашиглах нөхцөлд нөлөөлдөггүй гэдгийг харуулдаг. Бид бохирдсон усыг гадагш ямар нэг байдлаар алдагдуулахгүйн тулд өрмийн туслан гүйцэтгэгч компаниудад бохирдлын сан эсвэл далан байгуулахад нь тусладаг. Далан гэдэг нь хадгалалтын танк зэрэг анхдагч савнаас ямар нэг бодис асгарах, гоожих тохиолдолд түүнийг барих зориулалттай хоёрдогч хадгалалтын систем юм. Орон нутгийн хэрэглээний усны худгуудад үзүүлж буй манай нөлөөллийн менежментийн талаар бид олон нийтэд мэдээлэлийг үр дүнтэй хүргэж, аливаа асуудлаар нээлттэй харилцан яриа өрнүүлэх талаар ажилладаг билээ.

Занаду компани ус гэх ховор нөөцийг хамгийн үр дүнтэй байдлаар ашиглах талаар үргэлжлүүлэн төлөвлөгөө гаргаж байна. Түүхий усны хангамжийг Хармагтай Ашиглалтын Тусгай Зөвшөөрлийн хүсэлтэд зааснаар Хармагтайгаас 8км зайд байрлах усны эх үүсвэрээс хангахаар төлөвлөсөн. Усны анхдагч хэрэгцээ жилд 15 гега литр орчим байх ба, үйлдвэрийн өргөтгөл хийгдсэний дараа 30 гега литр орчим болж нэмэгдэнэ. Усыг төслийн талбай руу шугам хоолойгоор дамжуулах ба түүхий усыг хүдэр баяжуулах зорилгоор ашиглах бол ус цэвэршүүлэх үйлдвэрээс ундны ус гаргах болно.

Ус цэвэршүүлэх үйлдвэр нь хүдэр баяжуулах үйлдвэр, уурхайн оффис болон ажилчдын сууцны кэмп дотор төлөвлөгдсөн. Өөр нэг ус нийлүүлэх эх үүсвэр нь 40км зайд Таван Толгой цахилгаан станцад зориулан байгуулсан талбай дээр, бүрэн баригдсан боловч ашиглалтгүй байгаа болно. Аль аль нь үйлдвэрлийн зориулалттай усыг ундны зориулалттай болгон цэвэршүүлэх төхөөрөмж ашиглана. Урьдчилсан ТЭЗҮ-д бусад усны эх сурвалжуудыг байгаль орчин, нийгэм, тогтвортой байдал, техникийн үзүүлэлтүүд дээр үндэслэн үнэлнэ





Газар болон Биологийн төрөл зүйлийн менежмент



Занаду компани өөрсдийн үйл ажиллагаа явуулж буй газрыг хүндэтгэн үзэж, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг аль болох бага байлгахыг эрмэлздэг

2022 оны санхүүгийн жилд тус компани байгаль орчны хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй шалтгаанаар ямар нэг торгууль, шийтгэл хүлээсэн тохиолдол байхгүй. Манай өрмийн машинууд Хармагтай болон Улаан Уул талбайд бага хэмжээний (20м*20м) талбайд ажилладаг ба бид өрмийн ажил дууссаны дараа тухайн талбайг нөхөн сэргээж, нутгийн биологийн төрөл зүйлд үзүүлэх хайгуулын үйл ажиллагааны нөлөөллийг хамгийн бага түвшинд хүргэдэг. Манай Тогтвортой Байдлын Бодлогыг боловсруулахдаа газрыг аль болох бага хөндөх, үйл ажиллагаа хийгдэж дууссаны дараа нөхөн сэргээх нөхцлийг тусгасан. Зарим үйл ажиллагаанаас дурдвал:


Дээж авсан газруудыг мал амьтанд аюул учруулахааргүйгээр, болгоомжтой тэмдэглэх;

- Дээж авах цэгүүдийг малд аливаа хор хөнөөл учруулахгүй байдлаар тэмдэглэдэг;
- Дээж авах ажиллагааны явцад өнгөн

хөрсөн дэх хөрс, ургамлыг салган авч, дээж авсны дараа буцаан байрлуулдаг;

- Зөвхөн шаардлагатай үед суваг ухах ба хөрсөн бүрхэвчийг тусад нь хадгалдаг. Зураглал хийж, дээж авсны дараа сувгийг хааж, хөрсний давхаргаар хучиж, дахин ургамалжуулдаг.
- Налуу газарт хөрсний нуралт үүсэхээс хамгаалж урьдчилан сэргийлэх ус зайлуулах суваг гаргадаг,
- Талбайн үйл ажиллагааны дараа нэн даруй байгалийн төрөлх өвсний үр, ургамлаар буцаан нөхөн сэргээх арга хэмжээ авдаг.

Бид нутгийн ургамал, амьтны аймгийг болгоомжтой удирдах, зэрлэг болон тэжээвэр амьтадтай ямар нэг байдлаар холбогдохгүй байх, нутгийн ургамлын төрөл зүйлийг хамгаалах, урьдчилсан зөвшөөрөл авахгүйгээр аливаа ургамлыг устгах, гэмтээхгүй байхыг эрмэлзэж ажилладаг.



Уурхайн хөгжүүлэлт, үйл ажиллагаа, хаалтын шатанд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулна.

Хармагтай төсөл нь хүн ам цөөн суурьшсан, тэгш гадаргуутай газар нутагтай, зөвшөөрөл авах үйл явц тогтсон бөгөөд авах боломжтой, бид орчин үеийн техник технологи болон практик ашиглан эрчим хүчний хувьд хэмнэлттэй, аюулгүй, эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар хэрэгжүүлэхээр зорьж буй тул байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэл (ESG) харьцангуй бага юм. Авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдээс дурдвал:

- Хөдөлгөөнт хэрэгслийн цахилгаанжуулалт: бүрэн цахилгаан машин тоног төхөөрөмж хэрэглэх нь гүний уурхайд дизельтэй холбоотой үүсэх эрсдэл, халалт, хөргөлтийн шаардлагыг эрс бууруулна.
- Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжүүд бохирдол болон тээврийн зардлыг бууруулна.
- Туузан дамжуурга: материалыг гадаргуу руу туузан дамжуургаар тээвэрлэснээр дизель тоног төхөөрөмжийг ашиглалтаас гаргаж, бохирдлыг бууруулахын зэрэгцээ замын хөдөлгөөнтэй холбоотой аюулгүй байдлын нөхцлийг сайжруулж, мөн уурхай өөрчлөгдөж, томрохын хэрээр дорвитой шийдлүүдийг санал болгох болно.
- Орчин үеийн нэвтрэлт: төсөл далд уурхайн хэлбэрээр хэрэгжих тохиолдолд блок олборлолтын арга ашигласнаар тонн тутамд ногдох эрчим хүчний хэрэглээг бууруулж, өндөр эрсдэлтэй орчинд ажиллах хүн хүчний тоог бууруулах болно.
- Далд уурхайн боловсруулалт: төсөл далд уурхай хэлбэрээр хэрэгжих тохиолдолд далд уурхайд бутлуур, шигших тоног төхөөрөмж ашигласнаар гадаргуу руу гаргах материалын хэмжээг бууруулна.
- Гадаргуу дээрх боловсруулалт: гадаргуу дээр дараагийн шатны боловсруулалт хийснээр баяжуулах төхөөрөмж рүү орох материалын хэмжээ багасч, тэр хэмжээгээр эрчим хүчний зарцуулалт буурч устгах, нөхөн сэргээх хаягдал хүдрийн хэмжээ мөн буурах болно.
- Ногоон эрчим хүч: төвлөрсөн системийн эрчим хүч ашиглах замаар Монгол Улсын нарны болон салхины цэвэр эрчим хүч нийлүүлэгч нарыг дэмжиж, тэдэнтэй хамтран ажиллаж, орон нутгийн нүүрсний станцад очих эрэлтээс үүдэх хоёрдогч нүүрстөрөгчийн ялгарлыг бууруулна.
- Төмөр замын тээвэр: Монголын төмөр зам дэд бүтэц Хармагтайгаас 7км зайд ирснээр баяжмалын тээвэрт шаардагдах эрчим хүчний хэрэгцээ буурч, авто зам дээр ашиглах холын тээврийн автомашины тоо мөн буурах болно.
- Хаягдал хүдэр: Хоёр толгод хооронд далан барин хаягдлын овоолгыг хийснээр 10 орчим жил ашиглах боломжтой болно. Уурхайн ашиглалтын хугацааны туршид ашиглах хаягдал хүдрийн овоолгын эцсийн шийдлийг урьдчилсан ТЭЗҮ-д тусгана.

Олон Улсын Уул Уурхай Металлын Зөвлөл


Занаду тогтвортой байдлын гүйцэтгэлийн зохих стандартыг Олон Улсын Уул Уурхай Металлын Зөвлөл (ОУУМЗ)-ийн Тогтвортой Хөгжлийн Тогтолцооны дагуу байх нь хамгийн сайн практик болно гэж үздэг. Бид ОУУМЗ-ийн 10 зарчмыг нэвтрүүлэхийг зорин ажиллаж байна. Энэ талаар дараах хүснэгтэд тоймлон үзүүлэв.

ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
1-р зарчим Бизнесийн ёс зүйтэй үйл ажиллагаа, компанийн засаглал, ил тод байдлын зөв тогтолцоог хэрэгжүүлэх	Занаду компанийн ёс зүйн дүрэм болон авлига хээл хахуулийн эсрэг бодлого нь ёс зүйтэй үйл ажиллагаа хэрэгжүүлэлтийг зохицуулдаг. Шинээр ажилд орж буй ажилтан бүр сургалтанд хамрагдаж дүрэм журамтай танилцдаг.	Тогтвортой байдлын засаглал (хуудас 21)
2-р зарчим Тогтвортой хөгжлийг компанийн стратеги болон шийдвэр гаргах үйл явцад нэгтгэх.	Тогтвортой хөгжлийг компанийн шийдвэр гаргах үйл явцад нэгтгэсэн ба ТУЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд байгаль орчны хороо, Аудит, эрсдэлийн хороо нь зохицуулан удирддаг. Тогтвортой байдлын бодлогын баримт бичиг компанийн гол зорилго, зорилтууд тусгагдсан.	Тогтвортой байдлын бодлого (хуудас 26, 27)
3-р зарчим Явуулж буй үйл ажиллагаанаас хамаарч хүн бүрийн хүний эрх, соёл, зан заншил, үнэт зүйлс, ашиг сонирхолыг хүндэтгэх.	Хүний эрхийг эрхэмлэх, соёл, үнэт зүйлсийг хүндэтгэх зэргийг Занаду компани нь орон нутгийн иргэдийг дэмжиж хамтарч ажиллах, малчин, айл өрхүүдийн усны хангамж, оюутны тэтгэлэгт дэмжлэг үзүүлэх гэх зэрэг төслүүдээр дамжуулан биелүүлдэг. Дэлгэрэнгүй мэдээллийг ХХ дугаар хуудаснаас харна уу.	Байгаль орчныг хайрлан хамгаалах: орон нутгийн иргэдийг дэмжих (хуудас 36, 43)
4-р зарчим Шинжлэх ухаан, өгөгдөл мэдээлэлд суурилсан эрсдлийн удирдлагын үр дүнтэй стратеги, тогтолцоог хэрэгжүүлэх.	Занаду компанийн Эрсдлийн удирдлага, Тогтвортой байдлын бодлогын хүрээнд ТУЗ-ийн доорх Аудит, Эрсдлийн дэд хороо нь эрсдлийн удирдлагыг зохицуулан хэрэгжүүлдэг.	Тогтвортой байдлын бодлого (хуудас 21)
5-р зарчим Эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах.	Тогтвортой байдлын бодлого болон бусад холбогдох стандартыг Занаду компанийн ТУЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны дэд хороо нь удирдан хэрэгжүүлдэг.	Аюулгүй ажлын байрыг бий болгох (хуудас 33)
6-р зарчим Байгаль орчны гүйцэтгэлийн асуудлуудыг тасралтгүй сайжруулахыг эрмэлзэнэ.	Занаду компанийн ТУЗ-ийн доорх Аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчны дэд хороо нь байгаль орчны гүйцэтгэлийг компанийн Тогтвортой байдлын бодлого болон бусад холбогдох стандартуудын хүрээнд хүрээлэн буй орчинд үлдэх ул мөрийг бууруулахад удирдан хэрэгжүүлдэг.	Байгаль орчныг хайрлан хамгаалах (хуудас 43)

ICMM зарчим	Бидний зорилт	Хуудас
7-р зарчим Биологийн олон төрөл байдал Байгаль хамгаалахад болон газар ашиглалтын төлөвлөлт, нэгдсэн арга барилд хувь нэмрээ оруулна	Занадугийн ажилчид үйл ажиллагаа явуулж байгаа газраа талбайн байгаль орчны стандартыг дагаж мөрдөх замаар газар нутаг, унаган ургамлыг нь хадгалж амьтны аймаг, түүний нөлөөлөл багасгахыг хичээдэг.	Байгаль орчинд санаа тавих нь (page 43)
8-р зарчим. Хариуцлагатай бүтээгдэхүүн боловсруулалт, ашиглалт, дахин ашиглалт, дахин боловсруулалт, устгалтыг дэмжих бий болгох	Занадугийн хамрах хүрээний судалгаа нь, цаашдын хөгжилд зориулагдсан аюулгүй байдал болон орчин үеийн шаардлага хангах бүтээгдэхүүн, нөөцийг хамгийн үр ашигтай боловсруулах дахин ашиглах, хог хаягдал үйлдвэрлэл багасгах, хаягдлыг устгах хариуцлагатай үйл ажиллагаа явуулах орчин үеийн үйл ажиллагааны систем технологи боловсруулж байна.	Уур амьсгалын өөрчлөлт (page 44)
Principle 9 Бидний үйл ажиллагаа явуулж буй нийгэмлэг нийгэмд эдийн засгийн болон институцийн хөгжилд хувь нэмэр оруулах,	Занаду бат бөх харилцааг хадгалж, нийгэм эдийн засаг, зохион байгуулалтын боломжууд чухал болохыг ойлгож, олон нийтийн бүтээн зохион байгуулсан үйл ажиллагаанд тогтмол оролцдог. Бид орон нутгийн иргэд тэдний урт хугацааны хөгжил, ирээдүйн өсөлтийн боломжуудыг дэмжиж, утга учиртай хувь нэмэр оруулж байгаагаараа бахархдаг.	Орон нутгийн дэмжлэг (хуудас 36)
10-р зарчим Нээлттэй, ил тод байдлаар гол оролцогч талуудыг идэвхтэй оролцуулж, ахиц дэвшил, гүйцэтгэлийг үр дүнтэй тайлагнаж, бие даан шалгах механизмыг бүрдүүлэх.	Тогтвортой байдлын бодлоготойгоо уялдуулан оролцогч талуудтай байнгын хамтын ажиллагаа үүсгэх замаар аюулгүй, эрүүл ажлын нөхцлийг бий болгож ажилладаг. Оролцогч талуудын хэрэгцээ шаардлагыг ойлгосноор бидний бизнес болон орон нутгийн иргэдийн өсөлт хөгжил дээшилдэг.	Тайлангийн танилцуулга (хуудас 28-29)

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (НҮБТХЗ) нь хүн бүхэнд илүү сайн, илүү тогтвортой ирээдүйг бий болгох глобал хөгжлийг бий болгох тогтолцоо юм. Занаду компанид бид энэ тогтолцоог бүрэн дэмжиж, эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллахыг зорьж байна. Зарим зорилгууд нь Занаду компанид илүү хамааралтай бөгөөд үүнд:



3 - Эрүүл мэндийг дэмжих, 4 - Чанартай болвсролыг дэмжих, 6 - Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах, 8 - Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох, 11 - Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих, 13 - Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах, 15 - Хуурай газрын экосистемийг хамгаалах, 16 - Энх тайван, шударга ёсыг цогцлоох



Глобаль Тайлагналын Санаачлагын Индекс

Мэдээлэл	Тайлбар	Тайлан дахь байршил/шууд хариу
ГТС102: Ерөнхий мэдээлэл		
102-1 Байгууллагын нэр	Занаду Майнз	
102-2 Үйл ажиллагаа, брэнд, бүтээгдхүүн, үйлчилгээ	Занаду Майнз компанийн тухай бүлэг Хуудас 8	
102-3 Төв оффисын байршил	Австрали 2000, Шинэ Өмнөд Уэльс Сидней, Жорж гудамж 680, 12 давхар	
102-4 Үйл ажиллагааны байршил	Компанийн танилцуулга Хуудас 10-11	
102-5 Өмчлөл ба хуулийн этгээдийн хэлбэр	Занаду Майнз Лтд компанийн хувьцааг Австралийн Хөрөнгийн Бирж болон Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр арилжаалдаг (ASX, TSX код: ХАМ)	
102-6 Зах зээлүүд	Олборлолт ба нөөц баялаг	
102-7 Байгууллагын цар хүрээ	2022 оны календарийн жилийн тайлан: Үйл ажиллагааны үр дүн хэсэг Хуудас 13	
102-8 Ажилтнууд, бусад ажилчдын мэдээлэл	Бидний хүмүүс хэсэг Хуудас 30	
102-10 Байгууллага болон түүний нийлүүлэлтийн сүлжээнд гарсан томоохон өөрчлөлтүүд	Зижинь Уул Уурхайн Групптэй тогтоосон стратегийн түншлэл хэсэг Хуудас 12	
102-11 Урьдчилан анхааруулах зарчим	2022 оны календарийн жилийн тайлан: Үйл ажиллагааны үр дүн хэсэг Хуудас 16	
102-12 Гадны санаачлага	Нутгийн иргэдэд чиглэсэн бодлого хэсэг Хуудас 36-37	

Мэдээлэл	Тайлбар	Тайлан дахь байршил/шууд хариу
102-13 Холбооны гишүүнчлэл		Бид Монгол Улсын Уул Уурхайн Ассоциаци болон Австралийн Худалдааны Танхимын гишүүн юм.
102-14 Эрх бүхий этгээдийн мэдэгдэл		ТУЗ-ийн Дарга болон Ерөнхий Захирлын мэндчилгээ Хуудас 4
102-16 Үнэ цэн, зарчим, стандарт, ёс зүйн хэм хэмжээ		Ил тод, ёс зүйтэй ажиллах нь хэсэг Хуудас 24
102-18 Засаглалын бүтэц		Засаглалын хэсэг Хуудас 21
102-40 Оролцогч бүлгүүдийн жагсаалт		Оролцогч талуудын хамтын ажиллагаа хэсэг Хуудас 29
102-41 Хамтын гэрээ хэлэлцээр		Тэг
102-42 Оролцогч талуудыг тодорхойлж, сонгох нь		Оролцогч талуудын хамтын ажиллагаа хэсэг Хуудас 28
102-43 Оролцогч талуудын оролцооны хандлага		Оролцогч талуудын хамтын ажиллагаа хэсэг Хуудас 28
102-45 Санхүүгийн тайлангийн нэгтгэлд орсон аж ахуйн нэгжүүд		2022 оны календарийн жилийн тайлан: Үйл ажиллагааны үр дүн хэсэг Хуудас 42
102-46 Тайлангийн гол агуулга, хамрах хүрээ		Бодит байдлын үнэлгээ хэсэг Хуудас 17
102-47 сэдвүүдийн жагсаалт		Сэдвүүд хэсэг Хуудас 18-19


Глобаль Тайлагналын Санаачлагын Индекс

Мэдээлэл	Тайлбар	Тайлан дахь байршил/шууд хариу
Давтан мэдэгдэл		Тэг
Тайлангийн өөрчлөлтүүд		ГТС Тогтвортой Байдлын Тогтолцоонд нийцүүлэх нь
102-50 Тайлангийн хугацаа		Тайлангийн хамрах хугацаа: 2022.01.01 – 2022.12.31
102-51 Хамгийн сүүлийн тайлангийн огноо		2022 оны 06 сарын 09 өдөр
Тайлангийн мөчлөг		Жилийн
102-53 Тайлантай холбоотой асуултын хариулт, мэдээлэл авах		Спэнсэр Коул spencer.cole@xanadumines.com
102-54 ГТС Стандартын дагуу тайлангийн мэдэгдлүүд		Энэхүү тайланг ГТС Стандарт /Core Option/-ийн дагуу бэлтгэсэн болно
102-55 ГТС Асуулгын Индекс		Тайлангийн энэхүү хэсэг нь компанийн агуулгын индексийг илэрхийлнэ
102-56 Гадны баталгаажилт		Энэхүү Тайланг Морроу Содали дахь манай түншүүд хамтран бэлтгэв.

Тайлбар	Тайлан дахь байршил / шууд хариу	Холбоотой ТХЗ-ууд
ГТС 205 Авлигын эсрэг 205-1		
205-1 Авлигын эрсдэлтэй холбоотой үнэлгээ хийгдсэн үйл ажиллагаанууд	Занаду компани Монгол Улсад хайгуулын 2 тусгай зөвшөөрлийн талбайтай бөгөөд гол шийдвэрүүд гарах үед уг талбайнууд дээр авлигын эрсдэлийн үнэлгээ хийгдсэн. Гол шалгуур нь шийдвэр тус бүрийн харьцангуй ач холбогдол, хувийн жин (гэрээний үнийн дүн гэх мэт) дээр үндэслэнэ. Занаду нь Австралид (компанийн хэмжээний) болон Монголд (зөвхөн Монгол дахь үйл ажиллагааны хүрээнд) аудит хийлгэсэн бөгөөд эдгээр аудитыг өөр өөр аудитын компаниуд хийж гүйцэтгэсэн болно.	
205-2 Авлигын эсрэг бодлогын мэдээлэл, сургалт	Занаду нь одоо ажиллаж байгаа болон шинэ ажилтнууд, мөн ТУЗ-ийн гишүүдийг Авлига, Хээл Хахуулийн Эсрэг Бодлогын сургалтанд 100% хамрагдсан байхыг шаарддаг ба тус сургалт нь жил бүр явагддаг. Үүнээс гадна Санхүү Эрхэлсэн Захирал жил бүр мэдэгдэл гаргаж үүнийг баталгаажуулдаг. Занаду компанийн Авлига, Хээл Хахуулийн Эсрэг Бодлогыг дараах холбоосоор орон үзэж болно: XAM-Anti-Bribery-and-Corruption-Policy.pdf (xanadumines.com)	
205-3 Авлигын батлагдсан тохиолдлууд болон авсан арга хэмжээнүүд	2022 оны календарийн жилд авилгын зөрчил, тохиолдол гараагүй.	

Глобаль Тайлагналын Санаачлагын Индекс

Тайлбар	Тайлан дахь байршил / шууд хариу	Холбогдох ТХЗ-ууд
ГТС 206 Өрсөлдөөний эсрэг зан төлөв		
206-1 Өрсөлдөөний эсрэг зан төлөв, итгэлийн эсрэг, монополь практикт авах хуулийн арга хэмжээ	Занаду компанид 2022 оны календарийн жилд авсан өрсөлдөөний эсрэг зан төлөв, итгэлийн эсрэг, монополь практикт авах хуулийн арга хэмжээний тухай мэдээлэл алга байна.	
ГТС 303 Ус ба хаягдал ус		
303-1 Ус – дундын нөөц	Усны менежмент хэсэг хуудас 46	
ГТС 304 Биологийн төрөл зүйл		
304-3 Хамтгаалалтанд авсан эсвэл нөхөн сэргээсэн орчин	Газар болон биологийн төрөл зүйл хэсэг хуудас 48	
ГТС 305 Хүлэмжийн хий		
305-1 Шууд (1-р зэрэглэл) Хүлэмжийн хий ялгаруулалт	Эрчим хүч, хүлэмжийн хийн ялгаруулалтын менежмент хэсэг хуудас 44	
305-2 Эрчим хүч (Шууд бус) (2-р зэрэглэл) Хүлэмжийн хий ялгаруулалт	Эрчим хүч, хүлэмжийн хийн ялгаруулалтын менежмент хэсэг хуудас 44	

Тайлбар	Тайлан дахь байршил / шууд хариу	Холбогдох ТХЗ-ууд
ГТС 307 Байгаль орчны комплекс шийдэл		
307-1 Байгаль орчны хууль тогтоомжийг дагаж мөрдөхгүй байх	Газар ба биологийн олон янз байдлын хэсэг 48-р хуудас	
ГТС 404 Сургалт, боловсрол		
404-1 Жил бүр нэг ажилтанд ногдох сургалтын дундаж цаг	Манай хүмүүс хэсэг хуудас 30	
404-2 Ажилтны ур чадварыг нэмэгдүүлэх хөтөлбөр, шилжилттэй холбоотой тусламжийн хөтөлбөр	Ажилтны ур чадвар, боломжийг хөгжүүлэх, карьерын хөгжилд дэмжлэг үзүүлэх хэсэг хуудас 34	
ГТС 403 Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуй		
403-1 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн систем	Аюулгүй, эрүүл ажиллагааг хангах нь хуудас 33	
403-8 Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн системд хамрагдсан ажилчид	Манай ажилтнууд 100% хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн менежментийн системд хамрагдсан. Аюулгүй, эрүүл ажиллагааг хангах нь хуудас 33	

Глобаль Тайлагналын Санаачлаг а /GRI / индекс

Тайлбар	Тайлан дахь байршил / шууд хариу	Холбогдох ТХЗ-ууд
ГТС 403 Хөдөлмөрийн аюулгүй байдал Эрүүл ахуй		
403-19 Ажлын байрны осол гэмтэл	Аюулгүй, эрүүл ажиллагааг хангах нь хуудас 33	
403-10 Мэргэжлээс шалтгаалах өвчин	Аюулгүй, эрүүл ажиллагааг хангах нь хуудас 33	
ГТС 413 Орон нутгийн ард иргэд		
413-1 Орон нутгийн ард иргэдийн оролцоог хангах, нөлөөллийн үнэлгээ, хөгжлийн хөтөлбөрүүд	Манай бүх үйл ажиллагаанд орон нутгийн ард иргэдийн оролцоог хангадаг. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл манай Олон Нийтийн Харилцаа хэсэг хуудас 36-г үзнэ үү.	  

Байгууллагын удирдлага

Захирлууд

Колин Мурхэд

ТУЗ-ийн дарга болон Удирдах захирал

Ганбаяр Лхагвасүрэн

Монгол дахь Гүйцэтгэх захирал

Мишэл Муило

ТУЗ-ийн хараат бус гишүүн, захирал

Тони Пирсон

ТУЗ-ийн хараат бус гишүүн, захирал

Шаоян Шэн

Гүйцэтгэх бус захирал

Компанийн нарийн бичиг

Билл Ханди

Бүртгэлтэй хаяг - Австрали улс

c/o Company Matters Pty Limited

Level 12, 680 George Street

Sydney NSW 2000

Утас: +61 2 8280 7497

Факс: +61 2 9287 0350

Бүртгэлтэй хаяг - Монгол улс

Улаанбаатар 14240,

Сүхбаатар Дүүрэг, 1-р хороо, Олимпийн гупамж,

9Б Байр, 23 тоот

Утас: + 976 11 7012 0211

Хувьцааны бүртгэл

Computershare Investor Services Pty Limited

Level 3, 60 Carrington Street

Sydney NSW 2000

Утас: +61 1300 855 080

Аудитор

Ernst and Young

200 George Street

Sydney NSW 2000

Хөрөнгийн Биржийн бүртгэл

Xanadu Mines Ltd компани Австралийн Үнэт

Цаасны Бирж болон Торонтогийн Хөрөнгийн

Биржид бүртгэлтэй (ASX and TSX code: XAM)

Вэб хуудас

www.xanadumines.com

ABN

92 114 249 026

Corporate Governance Statement

Байгууллагын засаглалын мэдээллийг

компанийн вэб хуудсаас үзэж болно:

www.xanadumines.com/corporate-governance/



@XanaduMines_ASX



au.linkedin.com/company/xanadu-mines-limited







XANADU MINES